


Үндэсний хөгжлийн газрын даргын  
2020 оны 06 сарын 22 өдрийн 114 тоот  
тушаалын 2 хавсралт



**УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ТӨСЛИЙН САНАЛ  
БЭЛТГЭХ ЗААВАРЧИЛГАА**

**2020 он**

## АГУУЛГА

1.	Төслийн саналын маягт, түүнийг бөглөх .....	2
1.1	Төслийн саналын маягт .....	2
1.2	Мэдээлэл бүрдүүлэлт .....	2
1.3	Төслийн саналын маягтыг бөглөх .....	2
1.3.1	Төслийн үндсэн мэдээлэл .....	3
1.3.2	Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин .....	6
1.3.3	Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө .....	8
1.3.4	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт .....	11
1.3.5	Урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл .....	13
1.3.6	Дэд бүтэц .....	15
1.3.7	Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ .....	16
1.3.8	Санхүү, эдийн засгийн шинжилгээ .....	20
1.3.9	Санхүүгийн шинжилгээ .....	23
1.3.10	Эдийн засгийн шинжилгээ .....	29
1.4	Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас .....	34
2.	УХОХ-ийн төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ .....	35
2.1	Төслийн хэрэгжилтийн тайлан .....	35
2.2	Хэрэгжилтийн тайлангийн хүснэгт .....	35
2.3	Төслийн саналын маягт, хэрэгжилтийн тайлангийн хүснэгтийн уялдаа .....	35
2.3.1	Төслийн нэр, хэрэгжих хугацаа .....	37
2.3.2	Ажлын явц .....	37
2.3.3	Санхүүжилтийн гүйцэтгэл .....	37

## УДИРТГАЛ

Энэхүү зааварчилгааны дагуу боловсруулсан төслийн санал, хамт ирүүлсэн төслийн баримт бичгийн иж бүрдлийн мэдээлэл нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгоход ашиглагдах үндсэн мэдээлэл болно.

Тус зааварчилгааны зорилго нь Төсвийн ерөнхийлөн захирагч /цаашид "ТЭЗ" гэх/ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр /цаашид "УХОХ" гэх/-т тусгах төслийн саналыг зохистой боловсруулж, холбогдох маягтыг нэгдсэн арга зүйгээр бэлтгэн, УХОХ-ийн төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг оновчтой болгоход оршино.

Уг зааварчилгааны хэрэглэгч нь УХОХ-т төсөл, арга хэмжээ тусгахаар санал хүргүүлэгч байгууллагын хариуцсан албан хаагч, ТЭЗ-ийн үнэлгээ, нэгдсэн дүгнэлтийг хэлэлцэн батлах эрх бүхий албан тушаалтан байна. Мөн Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох албан хаагч нь төслийн саналын маягт өөрчлөгдөхөд тус зааварчилгааг шинэчлэн найруулах үүрэгтэй ба санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох албан хаагчид УХОХ-т төсөл, арга хэмжээ тусгах үйл явцыг сайтар ойлгох үүднээс тус зааварчилгааг ашиглаж болно.

Зааварчилгааг УХОХ-т төслийн санал хүргүүлэгч ТЭЗ-аас гадна холбогдох бусад төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчид ашиглах тул аль болох олон салбарын онцлогийг харгалзан үзсэн ба нэн тэргүүнд төслийн саналын маягт бэлтгэх ерөнхий, үндсэн санааг тусгахаар зорьсон. Хөрөнгө оруулалтын төслийн хувьд хэрэгжиж буй салбар, бүс, орон нутаг, тухайн төслийн ажлын явц, санхүүжилтийн эх үүсвэр зэргээс хамаарч нөхцөл байдал нь харилцан адилгүй байдаг хэдий ч бүх мэдээллийг энд дурдвал хэт нуршсан, ойлгомжгүй болох тул зөвхөн үндсэн мэдээллийг нэгтгэн цэгцэлж, нийтлэг бөгөөд энгийн төсөл, арга хэмжээний жишгээр төслийн саналын маягтыг хэрхэн бэлтгэх талаар тайлбарласан болно.

Энэхүү зааварчилгаа нь УХОХ-т төсөл, арга хэмжээ тусгахаар санал боловсруулах шатнаас бэлэн болсон төслийн саналыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх хүртэлх үе шатыг хамрах ба агуулгын хувьд удиртгал, 2 бүлэг, хавсралт дахь төслийн саналын маягтаас бүрдэнэ. Удиртгал хэсэгт тус гарын авлагын ерөнхий агуулгыг, 1-р бүлэгт төслийн саналын маягтыг хэрхэн бөглөх талаар, 2-р бүлэгт УХОХ-ийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгтийг хэрхэн бөглөх талаар тус тус тайлбарласан болно.

# **1. ТӨСЛИЙН САНАЛЫН МАЯГТ, ТҮҮНИЙГ БӨГЛӨХ**

## **1.1 Төслийн саналын маягт**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт шинээр төсөл, арга хэмжээ /цаашид "төсөл" гэх/ тусгах санал гаргахдаа Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан төслийн саналын маягтын дагуу саналаа боловсруулж ирүүлнэ. Төслийн саналын маягт нь дор дурдсан бөгөөд Хавсралт 1-10-т үзүүлэв.

- Төслийн үндсэн мэдээлэл
- Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин
- Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө
- Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт
- Төслийн урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл
- Төслийн дэд бүтцийн хэрэгцээ
- Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ
- Санхүүгийн шинжилгээ
- Эдийн засгийн шинжилгээ
- Тайлангийн хүснэгт

Төслийн мэдээллийг 1-10 дугаар маягтын дагуу бэлтгэн маягтууд дахь давхардсан мэдээллийг хоорондоо холбоотой хүснэгт болгон тохируулж, зарим мэдээллийг дахин давтан бөглөх шаардлагагүй байхаар зохион байгуулсан. Саналын маягтыг боловсруулж дуусаад Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэхээс өмнө маягтад хавсаргасан "Төслийн бичиг баримтын бүрдлийг шалгах хуудас"-ын бөглөн, бүрэн байдлыг шалгана. Түүнчлэн УХОХ-т тусгагдаж, хэрэгжилт нь эхэлсэн төслийн хувьд жил бүр хэрэгжилтийн явцыг тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай. Тус тайлангийн хүснэгт нь төслийн саналын маягтын 10 дугаартай хүснэгт болно.

## **1.2 Мэдээлэл бүрдүүлэлт**

ТЭЗ нь төслийн санал боловсруулахдаа саналын маягтыг бөглөхөд шаардлагатай мэдээллийг бэлдэнэ. Төсөл тус бүрийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа /цаашид "ТЭЗУС" гэх/, техник, эдийн засгийн үндэслэл /цаашид "ТЭЗҮ" гэх/, зураг төсөл зэрэг төслийн нарийвчилсан мэдээлэл УХОХ-т тусгах санал хүргүүлэх үед бүрдээгүй бол гүйцээн ирүүлнэ. Харин дор дурдсан мэдээллийг урьдчилсан байдлаар ашиглан, холбогдох хэсгийг бөглөснөөр тодорхой үнэлгээ авах боломжтой.

- Салбарын/ Бүсчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
- Төсөлтэй холбогдох судалгааны үр дүн
- Өөр бүс, орон нутгийн ижил төстэй судалгааны үр дүн
- Өөр салбарын холбогдох судалгааны үр дүн
- Хариуцсан бүтцийн нэгж, албан хаагчийн хийсэн судалгаа
- Бусад холбогдох судалгааны үр дүн

## **1.3 Төслийн саналын маягтыг бөглөх**

Энэ хэсэгт төслийн саналын маягтыг хэрхэн бөглөх дарааллыг зургаар оруулж, дугаарлан үзүүлсэн. Мөн анхаарах зүйлсийг хүснэгт тус бүрээр тайлбарласан. Эдгээр хүснэгтийн шар өнгөтэй хэсгийг шууд бичиж бөглөх ба ногоон өнгөтэй хэсгийн мэдээлэл нь бусад хүснэгтээс холбоосоор орох тул бөглөх шаардлагагүй.

Төслийн үндсэн мэдээлэл			Хаваралч 1
№	Үзүүлэлт		Танилцуулга
1	Төслийн нэр		①
2	Төсөл хэрэгжих салбар		②
3	Төсөл хэрэгжих дэд салбар		
4	Төсөл хэрэгжих байршил	Аймаг, хот	③
		Сум, дүүрэг	
		Хааг	
5	Төслийн үндэслэл, шаврдлага		④
6	Төслийн танилцуулга		⑤
7	Төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж / тоног төхөөрөмж / үйл ажиллагаа		⑥
8	Хөрөнгө оруулалтаар бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ	Бүтээгдэхүүн, үйлчилгээний агуулга, зах зээлийн өнөөгийн төлөв байдал	⑦
		Нийгмийн эрэлт хэрэгцээ, шаврдлага	
		Эдийн засгийн эрэлт, хэрэгцээ, шаврдлага	
		Дэд бүтцийн хэрэгцээ, шаврдлага	
9	Бүтээн байгуулалтын зардлын эх үүсвэр		⑧
10	Төслийн нийт төсөвт өртөг: <i>/сая.төгрөгөөр илэрхийлэх ба төслийн нийт төсөвт өртвийн дүн байна/</i>		

### ① Төслийн нэр

Төслийн нэр нь төсвийн төсөл болон гадаадын зээл, тусламж зэрэгт тусгахаар санал оруулах үед хэрэглэсэн нэртэй ижил байна. Өөр өөр эх үүсвэрээс санхүүжих томоохон хэмжээний төслийн хувьд ерөнхий нэг нэртэй байна. Тухайн нэр нь төслийн ерөнхий агуулгыг илэрхийлсэн, тодорхой нэр байна.

### ② Төсөл хэрэгжих салбар, дэд салбар

Төсөл хэрэгжих салбар, дэд салбарыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон ангиллын дагуу тодорхойлно. Ангиллыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1 Төсөл хэрэгжих салбар, дэд салбар.

Салбар	Дэд салбар
Уул уурхай, хүнд үйлдвэр	Хүнд үйлдвэр
	Геологи, эрдэс баялаг
	Уул уурхай
Эрүүл мэнд	Эмнэлгийн үйлчилгээ
	Эм, эмнэлгийн тоног төхөөрөмж
Зам тээвэр	Авто зам
	Авто замын тээвэр
	Нийтийн тээвэр
	Төмөр зам
	Агаарын тээвэр
	Логистик
	Зам, гүүрийн байгууламж
Барилга, хот байгуулалт	Материал үйлдвэрлэл
	Барилга угсралт
	Зураг төсөл, хот төлөвлөлт
	Инженерийн дэд бүтэц
Байгаль орчин, аялал жуулчлал	Аялал жуулчлал
	Байгаль орчин

Салбар	Дэд салбар
Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэр	ХАА
	Хүнсний үйлдвэр
	Хөнгөн үйлдвэр
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	Спорт
	Боловсрол
	Соёл
Харилцаа холбоо, мэдээллийн технологи	Шинжлэх ухаан
	Мэдээллийн технологи
	Радио, телевиз, шуудан
Эрчим хүч	Харилцаа холбоо
	Эрчим хүч үйлдвэрлэл
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	Цахилгаан дамжуулалт
	Ажлын байр
Бусад	Нийгмийн хамгаалал
	Үйлдвэр, технологийн парк
	Агуулах
	Бусад

③ **Төсөл хэрэгжих байршил**

Төсөл хэрэгжих байршлын хэсэгт засаг захиргааны хамгийн бага нэгжийг бичнэ. Тухайлбал, нийт хотыг хамарсан төслийн хувьд хотын нэрийг, тодорхой байршилд барилга байгууламж барих төсөл бол хаягийг нарийвчлан бичнэ. Мөн 3-аас дээш байршилд хэрэгжих төслийн хувьд хүснэгтийн харгалзах хэсгийг нэмж бүх байршлын мэдээллийг оруулна. Барилга байгууламж барихгүй төсөл бол үндсэн үйл ажиллагаа явагдах төслийн байршлын мэдээллийг оруулна.

④ **Төслийн үндэслэл, шаардлага**

Төслийг хэрэгжүүлэх болсон үндэслэл, суурь нөхцөл буюу тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэхэд тухайн төсөл, арга хэмжээ ямар нөлөөтэй талаар товч тодорхой дурдана.

⑤ **Төслийн танилцуулга**

Төслийн онцлогийг тусгана. Үүнд 1) Зураг төсөл, 2) Хэрэглэгч, 3) Технологийн шийдэл, онцлог, 4) Өртөг, зардал зэрэг мэдээллийг багтаана.

Тухайлбал зам барих тохиолдолд улсын чанартай, хурдны, төлбөртэй гэх мэт замын төрлийг дурдахаас гадна хаанаас хаа хүрэх, зам дагуух иргэд, аж ахуйн нэгжид ямар нөлөө үзүүлэх (амьдралын орчныг сайжруулах, уурхайн үр ашгийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих гэх мэт) зэргийг тодорхой дурдана. Жишээлбэл: "Хурдны зам нь зузаан хучилттай, уулзвартай холбогдох хэсэгт олон түвшний огтлолцолтой, зураг төсөл, технологийн хувьд өндөр түвшний шийдэл шаарддаг, барилга угсралтын болон ашиглалтад орсноос хойш тусгай засвар арчилгаанд тодорхой хэмжээний зардал шаардлагатай байдаг тул хөрөнгийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжаас санхүүжүүлж, технологийн шийдлийг гадаадын зөвлөх инженерүүдийг оролцуулах замаар шийдвэрлэн, ашиглалт арчилгааг менежментийн багц болгон зохион байгуулна" гэх мэтчилэн тайлбарлана.

⑥ **Төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж (тоног төхөөрөмж) үйл ажиллагаа**

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дурдана. Бүрэлдэхүүн хэсгийг үйл ажиллагаагаар, бүс орон нутгаар, гэрээт ажлаар гэх мэт тухайн төсөлд нийцүүлэн хувааж болно.

⑦ **Хөрөнгө оруулалтаар бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ**

Төслийн хэрэгцээ шаардлага буюу төсөл хэрэгжүүлсний үр дүнд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ, шаардлагыг дараах байдлаар тодорхойлно. Бүтээгдэхүүн, үйлчилгээний агуулга, зах зээлийн өнөөгийн төлөв байдал Хөрөнгө оруулалт хийгдэж бүтээн байгуулалт дууссаны дараа тухайн барилга байгууламж эсвэл тоног төхөөрөмжийн тусламжтайгаар үйлдвэрлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар тодорхой дурдах ба тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэх улс, бүс, орон нутгийн зах зээлийн төлөв байдлыг дараах 4 нөхцөлийг харгалзан тодорхойлно.

а. Улс төр: Улс төрийн нөхцөл байдал, татварын тогтолцоо, хууль эрх зүйн орчин;

б. Эдийн засаг: Хэрэглээ, зах зээлийн чиг хандлага, валютын ханш, зээлийн хүүгийн өөрчлөлт, эдийн засгийн өсөлтийн хувь;

в. Нийгэм: Орон нутгийг хөгжүүлэх, төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний төрөл зүйлийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн сонирхол, чиг хандлагын өөрчлөлт;

г. Технологи: Технологийн шинэчлэл, патент, зөвшөөрөл, цахимжуулалт гэх мэт.

Нийгмийн эрэлт, хэрэгцээ, шаардлага

Эдийн засгийн эрэлт хэрэгцээ, шаардлага

Нийгэм, эдийн засгийн эрэлт, хэрэгцээ, шаардлагыг дараах 3 зүйлсийг харгалзан, бодитоор тодорхойлно.

а. Хэрэглэгч: Үйлчлүүлэгчийн эрэлт, хэрэгцээ

б. Өрсөлдөгч: Төсөл хэрэгжих бүс, орон нутагт ижил төстэй бүтээгдэхүүн үйлчилгээ бий эсэх, тэдгээрийн өнөөгийн байдал

в. Төсөл хэрэгжүүлэгч: Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн төслийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн үр ашигтай эсэх, зайлшгүй бөгөөд давтагдашгүй эсэх, тухайн байгууллагын хувьд хөгжих боломжтой эсэх зэргээс үзэхэд тохирох эсэх эсхүл төслийн зорилго, зорилтыг биелүүлэх чадамжтай эсэх.

Зарим төслийн хувьд дараах нөхцлүүдийг харгалзан бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох нь илүү оновчтой байж болно.

4P	4C
Бүтээгдэхүүн - Product	Хэрэглэгчийн үнэ цэнэ – Customer value
Үнэ - Price	Хэрэглэгчээс гарах зардал - Cost
Байршил - Place	Хэрэглэгчийн ая тух - Convenience
Борлуулалтын урамшуулал - Promotion	Хэрэглэгчийн харилцаа - Communication

– Дэд бүтцийн хэрэгцээ, шаардлага

Бүс, орон нутгийн хэмжээнд дэд бүтцийн хэрэгцээ бий эсэх талаар дурдана.

### ⑧ Бүтээн байгуулалтын зардлын эх үүсвэр

Энэ хэсэгт Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө хүснэгтээс хамгийн их дүнг эзэлж буй 2 хүртэлх эх үүсвэр (улсын төсөв, гадаадын эзэл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй) -ийг дурдана.

Зураг 2. Төслийн үндсэн мэдээлэл

		Төлөвлөж буй ашиглалтын хүчин чадвал / төлөвлөж буй ашиглалтын хүчин чадлыг он оноор өргөмж хэмжих нэгжийг (квт/цаг, тн/дөр) в.м тодорхой оруулна./	
12	Төслийн хэрэгжих хугацаа	Бүтээн байгуулалт	Нийт хугацаа: ..... жил Эхлэх он: ..... Дуусах он: ..... /
		Ашиглалтанд орсноос хойш	Нийт хугацаа: ..... жил Эхлэх он: ..... Дуусах он: ..... /

### ⑨ Төсөл хэрэгжих хугацаа

Бүтээн байгуулалт ба ашиглалтад орсноос хойших үйл ажиллагааны үе шатыг тус тусад нь оруулна. Бүтээн байгуулалт гэдэг нь тухайн төслийн гол цөм болсон барилга байгууламжийн газрыг худалдан авахаас эхлээд барилга угсралт, тоног төхөөрөмж суурилуулалт, туршилтын үйл ажиллагаа зэрэг ашиглалтад орох хүртэлх бүх үйл ажиллагааг хэлнэ.

Зураг 3. Төслийн үндсэн мэдээлэл

22	Холбогдох судалгаа, шинжилгээ	⑩	<input type="checkbox"/> Сууры судалгаа <input type="checkbox"/> Бодлогын судалгаа <input type="checkbox"/> ТЭЗҮС <input type="checkbox"/> ТЭЗҮ <input type="checkbox"/> Зураг төсөл <input type="checkbox"/> БОНБУ (ерөнхий нарийвчилсан) <input type="checkbox"/> Газрын зөвшөөрөл <input type="checkbox"/> Холбогдох тусгай зөвшөөрлүүд <input type="checkbox"/> Гэрээ <input type="checkbox"/> Бусад / /
23	Дэд бүтцийн хэрэгцээ	⑪	/Төсөл хэрэгжих байршилд байгаа дэд бүтцийг ашиглах бол/ <input type="checkbox"/> Эрчим хүч <input type="checkbox"/> Дулаан <input type="checkbox"/> Цэвэр ус <input type="checkbox"/> Технологийн ус <input type="checkbox"/> Цэвэрлэх байгууламж <input type="checkbox"/> Ариутгах татуурга <input type="checkbox"/> Мэдээлэл, харилцаа холбоо <input type="checkbox"/> Автозам <input type="checkbox"/> Төмөр зам <input type="checkbox"/> Бусад / / /Төсөл хэрэгжих байршилд одоо байгаа дэд бүтцийг өргөтгөх эсвэл шинээр байгуулах бол/ <input type="checkbox"/> Эрчим хүч <input type="checkbox"/> Дулаан <input type="checkbox"/> Цэвэр ус <input type="checkbox"/> Технологийн ус <input type="checkbox"/> Цэвэрлэх байгууламж <input type="checkbox"/> Ариутгах татуурга <input type="checkbox"/> Мэдээлэл, харилцаа холбоо <input type="checkbox"/> Автозам <input type="checkbox"/> Төмөр зам <input type="checkbox"/> Бусад / /
24	Хэрэгжих боломж	Нийт төслийн үндэслэл, хэрэгжих боломж	⑫
25	Эрсдэл	Төслийн эрсдэлийн түвшний үнэлгээ	⑬

⑩ **Холбогдох судалгаа, шинжилгээ хийгдсэн байдал**

Хавсралт 5. Төслийн урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл” хүснэгтийн мэдээллийн дагуу хийгдсэн судалгаа шинжилгээг тэмдэглэнэ. “Бусад” гэдгийг сонгосон бол судалгааны нэрийг тодорхой бичнэ.

⑪ **Дэд бүтцийн бэлэн байдал, хэрэгцээ**

Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах дэд бүтцийн бэлэн байдлын талаар Хавсралт 6. Дэд бүтцийн хэрэгцээ” хүснэгтийг ашиглан одоо байгаа дэд бүтэц болон шинээр байгуулах, өргөтгөх дэд бүтцийн аль нэгийг сонгож тэмдэглэнэ. “Бусад”-ыг сонгосон бол дэд бүтцийн нэрийг тодорхой дурдана.

⑫ **Хэрэгжих боломж**

Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу бүтээн байгуулалт ба ашиглалтад орсноос хойших үе шат дахь төслийн үйл ажиллагааны цар хүрээ, төслийн зорилго, зорилтын биелэлтэд шаардагдах ажлын хэмжээ, хэрэгжих цаг үе зэргийг харгалзан тухайн төслийг ерөнхийд нь дүгнэн, хэрэгжих боломж “сайн, дунд, муу, үнэлэх боломжгүй” гэдгийн аль нэгийг сонгож тэмдэглэнэ.

⑬ **Эрсдэл**

Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тодорхойлогдсон эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээг дүгнэн эрсдэлийн талаар ерөнхийд нь “өндөр, дунд, бага, үнэлэх боломжгүй” гэдгийн аль нэгийг сонгож тэмдэглэнэ.

**1.3.2 Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин**

Хавсралт 2. Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин хүснэгтэд тухайн төслийн улс, бүс, орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж буй эсэх, холбогдох хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх, бусад төсөл, арга хэмжээтэй уялдаж буй эсэхийг тодорхойлно.

Зураг 4. Бодлогын уялдаа, эрх зүйн орчин

Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин					
№	Үзүүлэлт	Нийцэх байдал	Хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох заалт	Бодлогын зорилго, зорилтыг хангахад үзүүлэх нөлөө	Төслийн хэрэгцээ шаардлага
<b>Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэх байдал</b>					
1	Урт хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал				
2	10 хурталж жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал			①	
3	5 хурталж жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	Сайн			
4	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал				
№	Үзүүлэлт	Уялдаа байдал	Уялдаа төсөл, арга хэмжээний нэр	Бусад төсөл, арга хэмжээний явц, товч агуулга	Уялдаа холбоо
<b>Бусад төсөл, арга хэмжээтэй уялдаа уялдаа, хамварал</b>					
1	УХОХ-т туссан тухайн салбар, бүс орон нутаг дахь бусад төсөл, арга хэмжээтэй уялдаа эсэх				
2	УХОХ-т тусавгүй тухайн салбар, бүс орон нутаг дахь төсөл, арга хэмжээтэй уялдаа эсэх			②	
3	Уялдан хэрэгжих ямар нэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байхгүй бол энэ тухай тодорхой тайлбарлах				
№	Үзүүлэлт	Бэлэн байдал	Хууль эрх зүйн акт, холбогдох тушаал шийдвэр	Хүчин төгөлдөр байдал	Төслийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөө
<b>Төслийн үндэслэл, хууль эрх зүйн орчин</b>					
1	Хууль эрх зүйн шаардлагад нийцэж буй байдал, төслийн үндэслэл	Бэлэн		③	

① **Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэх байдал**

Урт, дунд хугацааны хөгжлийн бодлого тэдгээрийн зорилго, зорилттой нийцэж буй эсэхийг харгалзах гарчгийн дагуу дүгнэж тэмдэглэнэ.

Нийцэх байдал

Тухайн төслийн бодлогын баримт бичигтэй нийцэх байдлыг ерөнхийд нь үнэлэх ба доорх 2 - 4)-т дурдсан үзүүлэлтийн харгалзах баганыг бөглөсний дараа “сайн, дунд, муу, тодорхойгүй” гэдгийн аль нэгийг сонгоно.



Хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох заалт

Хөгжлийн бодлого, түүний зорилго, зорилттой нийцэж буй бол тухайн бодлогын баримт бичгийн нэр, ерөнхий агуулгыг дурдана.

Бодлогын зорилго зорилтыг хангахад үзүүлэх нөлөө

Бодлогын зорилго, зорилтыг хангахад тухайн төсөл ямар нөлөө үзүүлэх талаар тайлбарлана.

Төслийн хэрэгцээ, шаардлага

Тухайн төслийн хэрэгжилтэд холбогдох хөгжлийн бодлого хэрхэн нөлөөлөхийг тайлбарлана.

② **Бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээтэй уялдах уялдаа, хамаарал**

Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах уялдаа, хамаарлын тухайд "УХОХ-т туссан тухайн салбар, бүс, орон нутаг дахь бусад төсөл, арга хэмжээтэй уялдах эсэх", "УХОХ-т тусаагүй тухайн салбар, бүс орон нутаг дахь төсөл, арга хэмжээтэй уялдах эсэх"-ийг тодорхойлно.

Энд дурдсан "бүс, орон нутаг" гэдэг нь төсөл тус бүрээр тодорхойлогдох бөгөөд бүс, аймаг, нийслэл, сум, дүүргийн аль нэг, өөрөөр хэлбэл тухайн төслийн хэрэгжих нутаг дэвсгэр юм. Тухайлбал, "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц"-ын төслийн хувьд хэрэглэгч нь зөвхөн Эрдэнэт хот бол Орхон аймгийн төсөл гэж үзнэ. Эрдэнэт хотод баригдах "Бүсийн оношилгоо, эмчилгээний төв"-ийн хувьд барилга байгууламж нь Орхон аймгийн Эрдэнэт хотод байрлах боловч үйлчилгээний хүрээгээр нь Хангайн бүсийн төсөл гэж үзнэ. Харин "Сумын төвийн шинэчлэл" төслийн тухайд аль нэг аймгийн бус, сумын түвшинд хэрэгжих төсөл тул сумын төсөл гэж үзэх ба бусад сумдад хэрэгжиж буй төслүүдтэй хэрхэн уялдахыг нягтална.

Мөн үндэсний хэмжээнд хэрэгжих төсөл, арга хэмжээний тухайд тухайн төслийн хэрэгжих үндэслэл болж буй үндэсний хэмжээний төсөл, хөтөлбөрийн нэрийг дурдана. Түүнчлэн тухайн нэг салбарт хэд хэдэн бүс, орон нутгийг дамнан хэрэгжиж буй төсөл байгаа бол тэдгээрийг дурдана. Үүнд өмнөх оны УХОХ-ийн төслийн жагсаалтыг лавлагаа болгон ашиглана.

Уялдах байдал

Тухайн төслийн бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдлыг ерөнхийд нь үнэлэх ба доорх (2 - 4)-т дурдсан үзүүлэлтийн харгалзах баганыг бөглөсний дараа "сайн, дунд, муу, тодорхойгүй" гэдгийн аль нэгийг сонгоно.

Уялдах төсөл, арга хэмжээний нэр

Уялдах төсөл, арга хэмжээний нэрийг дурдана.

Төсөл, арга хэмжээний явц, товч агуулга

Тухайн төсөлтэй уялдаа хиллүү бүхий төсөл, арга хэмжээний товч агуулга, хэрэгжилтийн явцыг тайлбарлана.

Уялдаа холбоо

Тухайн төсөл нь холбогдох төсөл, арга хэмжээтэй хэрхэн уялдаж байгаа талаар дурдана.

③ **Төслийн үндэслэл, хууль эрх зүйн орчин**

Тухайн төсөл нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх, төрөөс үзүүлэх тусгай дэмжлэг бий эсэх, холбогдох тушаал шийдвэр гарган эсэхийг тодорхойлж бичнэ. Татварын хөнгөлөлт, урамшуулал, чөлөөлөлт, экспорт, импортын квот, дэмжлэг, урамшуулал зэрэг нь төрийн зүгээс үзүүлэх дэмжлэгт багтана. Мөн тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тухайн хууль эрх зүйн актын нэрийг дурдана.

Бэлэн байдал

Тухайн төслийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг доорх 2)- 4)-т дурдсан баганын үзүүлэлтийг бөглөсний дараа “бэлэн, хараахан бэлэн бус, тодорхойгүй” гэдгийн аль нэгийг сонгон, үнэлнэ.

Хууль эрх зүйн акт, холбогдох түшээл шийдвэр

Холбогдох хууль эрх зүйн актын нэр, зүйл заалтын ерөнхий агуулгыг дурдана.

Хүчин төгөлдөр байдал

Тухайн хууль эрх зүйн акт хүчин төгөлдөр эсэх, үгүй бол батлагдах хугацааг дурдана.

Төслийн хэрэгжилтэд үзүүлэх нөлөө

Холбогдох хууль эрх зүйн акт нь төслийн хэрэгжилтэд хэрхэн нөлөөлөх талаар тайлбарлана.

**1.3.3 Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө**

Энэ нь тухайн төсөл санхүүжилт болон үйл ажиллагааны төлөвлөлтийн хувьд хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлж харуулах хүснэгт юм. Төслийн үйл ажиллагааг бүтээн байгуулалтын болон ашиглалтад орсноос хойших гэсэн 2 үе шатад хуваан холбогдох мэдээллийг оруулна.

Зураг 5. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө

Хаварлт. 3

Бүтээн байгуулалтын үе шат									
№	Үндсэн ажлууд	Нийт төлөвлөлт/Ерөнхий үнэлгээ/Тайлбар			Өнгөрсөн хугацааны төслийн явц/Тулгамдаж буй асуудал		Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө/Бүтэц, зохион байгуулалт/Эрсдэл		Тайлбар
					20- он	20- он	20- он	20- он	
	Он оноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө					①			
	Төслийн бүтэц, зохион байгуулалтын бэлэн байдал					②			
	Шинэ технологи					③			
	Учирч болох эрсдэл					④			
	Эрсдэл бууруулах арга хэмжээ								
№	Үндсэн ажлууд	Нийт төсөвт өртөг (аяа төг.)	Төлөвлөж буй эх үүсвэр	Урьдчилсан санхүүжилт	Өнгөрсөн хугацаанд кийгдсэн санхүүжилт		Санхүүжилтийн төлөвлөгөө/Батлагдсан төсөв		Тайлбар
					20- он	20- он	20- он	20- он	
1	Тонг төхөөрөмж								
2	Барилга								
3	Цалин хөлс	⑤	⑥	⑦		⑧		⑨	⑩
4	Бусад								
5	.....								
	Нийт								
	Төлөвлөж буй санхүүжилтийн хувь								

\* Өнгөрсөн хугацаанд ямар нэг санхүүжилт хийгдсэн бол гүйцэтгэл гарсан он сар өдөр, эх үүсвэрийг тайлбар хэсэгт өөрийн тусгай тэмдэгтээр тусгах.

**Бүтээн байгуулалтын үе шат**

① **Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг төслийн үе шатуудаар тодорхой тайлбарлах ба “Нийт төлөвлөлт / Ерөнхий үнэлгээ / Тайлбар” баганад төслийн нийт төлөвлөгөөг он тус бүрээр багцлан дурдана. “Өнгөрсөн хугацааны ажлын явц / Тулгамдаж буй асуудал” баганад УХОХ-т тусгахаар санал өгөхөөс өмнө хийгдсэн ажил, үйлчилгээ, гэрээт ажлын мэдээллийг тусгана. “Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө / Бүтэц, зохион байгуулалт / Эрсдэл” баганад төслийн явцыг он тус бүрээр тайлбарлана.

② **Төслийн бүтэц, зохион байгуулалтын бэлэн байдал**

Төсөл хэрэгжүүлэх нэгж эсхүл удирдлагын бүтцийг зохион байгуулах шаардлагатай бол холбогдох бэлтгэл ажил хэрхэн явагдаж буйг тайлбарлана. “Нийт төлөвлөлт /Ерөнхий үнэлгээ/ Тайлбар” баганад холбогдох бүтэц байгуулах төлөвлөгөөг, “Өнгөрсөн хугацааны ажлын явц /Тулгамдаж буй асуудал” баганад УХОХ-т тусгахаар санал өгөхөөс өмнө бүтэц,

зохион байгуулалтын талаар хийгдсэн ажлыг бичиж, "Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө/ Бүтэц, зохион байгуулалт/ Эрсдэл" баганад хийгдсэн ажлыг он оноор нь тодорхой тайлбарлана.

#### ③ Шинэ технологи

Тухайн төслийг хэрэгжүүлэхэд шинэ, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх бол процессыг тайлбарлана. "Нийт төлөвлөлт/Ерөнхий үнэлгээ/Тайлбар" баганад ямар техник, технологийг хэрхэн нэвтрүүлэх талаар, "Өнгөрсөн хугацааны ажлын явц/Тулгамдаж буй асуудал" баганад УХОХ-т тусгах санал өгөхөөс өмнө энэ талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааг, "Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө /Бүтэц, зохион байгуулалт/ Эрсдэл" баганад шинэ техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг он оноор нь дурдана.

#### ④ Эрсдэл бууруулах арга хэмжээ

Төслийн хэрэгжилтэд учирч болох эрсдэлийг тодорхойлж, нөлөөллийг хэрхэн бууруулах талаар бичнэ. Бүтээн байгуулалтын үе шатны эрсдэлд газар чөлөөлөлт, байгаль орчны асуудал, гуравдагч этгээдийн хохирлыг барагдуулах нөхөн төлбөрөөс гадна санхүүжилт доголдох, хууль эрх зүйн орчин, зураг төсөлд өөрчлөлт орох, бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалан барилга угсралтын зардал нэмэгдэх, давагдашгүй хүчин зүйл (урьдчилан тааварлашгүй байгалийн гамшиг болон хүний үйл ажиллагаатай холбоотой хохирол) тохиолдох зэрэг багтана.

"Нийт төлөвлөлт /Ерөнхий үнэлгээ/ Тайлбар" баганад эрсдэлүүд ба тэдгээрийн эсрэг авах арга хэмжээг, "Өнгөрсөн хугацааны ажлын явц /Тулгамдаж буй асуудал" баганад УХОХ-т тусгахаар санал өгөхөөс өмнө тодорхойлогдсон эрсдэл, тэдгээрийг бууруулах арга хэмжээг, "Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө/Бүтэц, зохион байгуулалт/ Эрсдэл" баганад төслийг хэрэгжүүлэх явцад үүсэж болох эрсдэл, тэдгээрийг бууруулах арга хэмжээг он оноор нь тодорхойлон бичнэ.

Эрсдэлийг тооцохдоо Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаээс баталсан "Хөрөнгө оруулалтын төслийн эрсдэлийн шинжилгээ хийх аргачлал"-ыг ашиглана.

#### ⑤ Нийт төсөвт өртөг

Төсөлд зарцуулагдах нийт зардлыг сая төгрөгөөр тооцож оруулна. Нийт төсөвт өртөгт газар, техник, тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламж барих болон бусад (цалин хөлс, шууд бус зардал гэх мэт) бүх зардлыг оруулан тооцно.

#### ⑥ Төлөвлөж буй санхүүжилтийн эх үүсвэр

Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалт, бусад гэдгээс сонгож бичнэ. Гадаадын зээл, тусламжийг "тайлбар" баганад зээл эсвэл буцалтгүй тусламж гэж ялган, түншлэгч байгууллагын нэрийг тодорхой дурдана.

#### ⑦ Урьдчилсан санхүүжилт

Урьдчилсан санхүүжилт, хөрөнгө оруулалт хийгдсэн бол тухай тодорхой бичнэ.

#### ⑧ Өнгөрсөн хугацаанд хийгдсэн санхүүжилт

Урьдчилсан санхүүжилт хэсгийг бөглөсөн бол тухайн жил бүрийн санхүүжилт хийгдсэн дүнг оруулна.

#### ⑨ Санхүүжилтийн төлөвлөгөө/ Батлагдсан төсөв

Хүснэгтэд 5 жилээр оруулсан боловч илүү олон жил хэрэгжих төслийн хувьд нийт хугацаанд харгалзуулан баганыг нэмж оруулна.

#### ⑩ Тайлбар

Төлөвлөж буй эх үүсвэрийн нөхцөл, урьдчилсан санхүүжилтийн нэмэлт тайлбар зэргийг тэмдэглэнэ. Мөн өнгөрсөн хугацаанд санхүүжилт хийгдсэн бол:

- Санхүүжилт хийгдсэн огноо (хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжилт хийгдсэн бол санхүүжилт нэг өдөр хийгдсэн байсан ч эх үүсвэр тус бүрээр, санхүүжүүлэгч нь ТЕЗ биш бол холбогдох байгууллага тус бүрээр ялгаж),
- Санхүүжилтийн зарцуулалт (тухайлбал, судалгаа захиалан гүйцэтгүүлсэн бол түүний зардал, судалгааны цар хүрээ, гүйцэтгэгчийн нэр зэргийг)
- Санхүүжилтийн дүн (сая төгрөгөөр)
- Эх үүсвэр (Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэл, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар ялгаж, гадаадын зээл тусламж бол түншлэгч байгууллагын нэр) -ийг тодорхой дурдана.

Зураг 6. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө

Ашиглалтанд орсноос хойш									
№	Үндсэн ажлууд	Ерөнхий үнэлгээ/ Тайлбар	Жилийн хүчин чадал	Хэмжих нэгж	Үйл ажиллагааны төлөвлөгөө/ Эрсдэл				Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр
					20-- он	20-- он	20-- он	20-- он	
	Он оюур төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө								
	Учирч болох эрсдэл								
	Эрсдэл бууруулах арга хэмжээ								
№	Үндсэн ажлууд	Нийт төсөвт өртөг/ Нийт хүчин чадал	Төлөвлөж буй эх үүсвэр	Урьдчилсан санхүүжилт	Үйл ажиллагааны үе шатны санхүүжилтийн төлөвлөгөө/ Төлөвлөж буй үйлдвэрлэлийн хүчин чадал				Тайлбар
					20-- он	20-- он	20-- он	20-- он	
1	Тоног төхөөрөмж								
2	Барилга								
3	Цалин хөлс								
4	Бусад								
5	.....								
	Нийт								
	Төслийн хүрээнд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ					①			

### **Ашиглалтад орсноос хойш**

Ашиглалтад орсноос хойш хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, эрсдэл, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, санхүүжилтийн төлөвлөгөөг бүтээн байгуулалтын үе шаттай харгалзуулан бичнэ. Ашиглалтад орсноос хойш учирч болох эрсдэлд шинэчлэн барих болон их засвар хийх, эрэлт буурах, гуравдагч этгээд (хэрэглэгч) барилга байгууламжид хохирол учруулах, гуравдагч этгээд (ойр орчмын оршин суугчид)-ийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарах зэргээс гадна удирдлага, хүний нөөцийн эрсдэл, үнийн өөрчлөлт багтана.

### **① Төслийн хүрээнд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ**

Төслийн ашиглалтын үе шатанд үйлдвэрлэх бүтээгдэхүүн, үзүүлэх үйлчилгээний хэмжээг дурдана. "Тайлбар" хэсэгт төслийн хүчин чадал (цар хүрээ)-ын хэмжих нэгжийг тодорхой бичнэ. Хэд хэдэн хэмжих нэгжээр хэмжигдэх бол хүснэгтэд шинээр мөр нэмж нийт төслийн цар хүрээ эсвэл төлөвлөгдөж буй үйлдвэрлэлийн хүчин чадлыг тус бүрд нь тэмдэглэнэ.

#### **Нийт хүчин чадал**

Тухайн төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээг хэмжих нэгж тус бүрээр нь тэмдэглэнэ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилго бүхий төслийн хувьд үйлдвэрлэгдэх бүтээгдэхүүний нийт хэмжээ байна. Бусад төслийн хувьд, тухайлбал, зам барилгын төсөл бол төслөөр барих замын нийт урт байна. Эмнэлгийн барилга бол орны тоо, сургуулийн барилга бол сурагчийн тоо байна.

#### **Төлөвлөж буй үйлдвэрлэлийн хүчин чадал**

Төлөвлөж буй үйлдвэрлэлийн хүчин чадлын хэмжих нэгж нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилго бүхий төслийн хувьд кВт/цаг, тонн/хоног гэх мэт нэгж байна. Бусад төслийн хувьд, тухайлбал, зам барилга бол хоногт зорчих тээврийн хэрэгслийн тоо, эмнэлэг

бол хоногт хүлээн авах өвчтөний тоо, сургууль бол нэмэлт элсэлтийг оруулахгүйгээр 1 жилд хүлээн авах суралцагчийн тоо байна.

Ашиглалтад орсноос хойш жил тутам хүчин чадал нь нэмэгдэхээр төлөвлөсөн бол ашиглалтад орсноос хойших 10 жилийг, жил бүрээр дурдана. Хүчин чадал өөрчлөгдөхгүй бол 2 дахь жилийн хэсэгт “дараагийн онуудад ч тогтмол” гэж тэмдэглэнэ.

### 1.3.4 Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

Энэ хүснэгтийг төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах зорилгоор боловсруулна. Эрхэм зорилгод Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын харгалзах шалгуур үзүүлэлтийг мөрдлөг болгох ба төслийн зорилго, зорилтыг тодорхойлохдоо тухайн төслийн онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлно. Зарчмын хувьд тоон үзүүлэлт байх ба тоон үзүүлэлтээр хэмжих боломжгүй эсвэл тохиромжгүй бол чанарын үзүүлэлтийг тогтоож болно.

Зураг 7. Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

Хавсралт. 4


Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт											
№	Зорилтууд	Шалгуур үзүүлэлтийн түвшин	Үнэлэх шалгуур үзүүлэлтийн нэр	Тайлбар	Суурь түвшин, өмнөх оны хэрэгжилт	Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн					
						20--он		20-- он		Эцсийн хүрэх түвшин	
						Тоон үзүүлэлт	Чанарын үзүүлэлт	Тоон үзүүлэлт	Чанарын үзүүлэлт	Тоон үзүүлэлт	Чанарын үзүүлэлт
1		Эрхэм зорилго									
2		Төслийн зорилго									
3	①	Зорилт 1 ②	③	④	⑤			⑥			
4		Зорилт 2									
5		Зорилт 3									
6		Зорилт 4									

### Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоос гадна төсөл хэрэгжиж дууссаны дараах нөлөөллийн үнэлгээнд ашиглана. Санхүүжилтийн эх үүсвэрээс шалтгаалан, тухайлбал гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, арга хэмжээ нь төсөл боловсруулах үе шатанд зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлсон байдаг тул тухайн тодорхойлсон үр дүнг удирдлага болгоно. Харин улсын төсвөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний хувьд ТЕЗ хүрэх үр дүн, зорилго, зорилтыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжтэй хэлэлцсэний үндсэн дээр тодорхойлж, тусгана.

Зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлохдоо тэдгээрийн уялдаа холбоог ойтөр бодолцон, логик хүрээний аргыг ашиглаж болно. Логик хүрээний аргыг 1960-аад оны сүүл үеэс АНУ-д ашиглаж эхэлсэн ба сүүлийн үед үр дүнд суурилсан удирдлагын (results based management: RBM) тогтолцоонд зорилгоо тодорхойлж, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг сонгох чухал хэрэгсэл болгон ашиглаж байна. Логик хүрээний арга нь төслийн стратегийг 4 мөр, 4 баганаас бүтэх “Төслийн төлөвлөлтийн матриц” болгон нэгтгэж, “төслийн эрхэм зорилго”, “төслийн зорилт”, “орц”, “үйл ажиллагаа”, “гарц” гэсэн шалтгаан – үр дагаврын уялдаагаар жагсаан, зорилго, үр дүнгийн хүлээгдэж буй түвшнийг шалгуур үзүүлэлтээр илэрхийлдэг. Энэ аргыг ихэвчлэн техникийн хамтын ажиллагааны төслийг боловсруулахад ашигладаг бөгөөд зорилго ба хүрэх үр дүн (төслийн үр нөлөө)-г тодорхойлоход логик уялдаа холбоог сайтар анхаарах нь зүйтэй. Тухайлбал, бага сургууль байгуулах төслийн зорилго, үр дүнг дараах логик уялдаагаар харж болно.

Зураг 8. Төслийн зорилго, зорилтын жишээ



Энэ жишээнээс харахад сургууль барих төслийг УХОХ-т тусгахаар санал гаргаж буй төсөл хариуцагч нь зорилго-1 буюу цэнхрээр хүрээлсэн хэсгийг “төслийн зорилго” гэж тодорхойлно. Гэхдээ нийт салбарын хувьд харахад төсөл нь “эрхэм зорилго-1” “эрхэм зорилго-2”-той холбогдож байгаа нь харагдана (улаан хүрээн доторх). Энэ тохиолдолд эрхэм зорилго, төслийн зорилгыг харгалзах хэсэгт бичиж, дэд зорилго/зорилтыг он тус бүрээр, мөн төслийн зорилго, эрхэм зорилгын зөвхөн зорьж буй түвшнийг тэмдэглэнэ.

① **Зорилтууд**

Төслийн ерөнхий агуулга буюу логик хүрээний аргад үндэслэн төслийн зорилгод хүрэхэд шаардлагатай үр дүнг бичнэ.

② **Шалгуур үзүүлэлтийн түвшин**

Шалгуур үзүүлэлтийн түвшнийг дурдсан “эрхэм зорилго”, “төслийн зорилго”, “төслийн зорилт”-оос сонгоно. Зарчмын хувьд эрхэм зорилго нэг байна. Гэхдээ төсөл бодлогын олон шалгуур үзүүлэлтэд хамаарах бол эрхэм зорилго нэгээс илүү байж болно. Төслийн зорилго мөн адил. Төслийн зорилт нь төслийн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн гэрээт ажилд үндэслэн тодорхойлогдох тул тооны хязгааргүй.

③ **Үнэлэх шалгуур үзүүлэлтийн нэр**

Тоон болон чанарын үзүүлэлтийн нэрийг бичнэ. Тоон үзүүлэлтийг тодорхойлохдоо дараах “SMART” зарчмыг баримтална.

Specific (зорилго тодорхой байх): Зорилгыг бодит бөгөөд тодорхой болгосноор шалгуур үзүүлэлтийн хэрэглэгч талууд нэгдсэн ойлголттойгоор ашиглах боломжтой болно. Тиймээс хийсвэр, бүрхэг үг хэллэг, агуулгаас зайлсхийнэ.

Measurable (хэмжиж болохуйц байх): Шалгуур үзүүлэлтийг хэмжиж болохуйцаар тогтоож, тодорхой хугацаанд хэмжиж, дүн шинжилгээ хийснээр төслийн зорилгод хүрэхэд хэр нөлөө үзүүлж байгааг мэдэх боломжтой болно.

Achievable (зорилгодоо хүрч болохуйц байх): Бодитоор хүрч болохуйц зорилго тавьснаар холбогдох талууд зорилгыг ойлгож, түүнд хүрэхээр ажиллах боломжтой болно. “Хүрч болохуйц зорилго” -ыг холбогдох бүх тал зөвшөөрч байх нь чухал. Харин бодит бус, ойлгомжгүй зорилго, зорилтын төлөө ажиллахад хүлээсэн үр дүн гарахгүй байх магадлал өндөр.

Relevant (уялдаа холбоотой байх): 1) Үр дүнгийн шалгуур үзүүлэлт ба нийт зорилгын уялдаа холбоо, 2) Үр дүн болон бодлогын уялдаа холбоо сайтар хангагдсан байх шаардлагатай. Энэхүү уялдаа холбоо муу бол төслийн үр дүнд хүрэх ч төслийн зорилго биелэхгүй байх магадлалтай.

Time-bounded (цаг хугацаатай байх): Бодит бөгөөд хэмжиж болохуйц шалгуур үзүүлэлтийг тогтоож, хэрэгжүүлэх хугацааг тодорхойлох шаардлагатай.

Зөвхөн тухайн төсөлд тохирсон шалгуур үзүүлэлтийг тогтоох бол шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгж олон төрөл байж болно. Өөрөөр хэлбэл, эрхэм зорилгын хүрэх үр дүн нь ямар нэг үзүүлэлтийг ...%-д хүргэнэ гэх мэтээр тодорхойлсон бол төслийн зорилго, зорилтыг жишээлбэл барилга угсралтын явц, давтамж, тоо ширхэг гэх мэт хэмжих нэгжээр илэрхийлж болно.

Зарчмын хувьд тоон үзүүлэлтийг ашиглах боловч тоон үзүүлэлтээр илэрхийлэхэд бэрхшээлтэй бол чанарын үзүүлэлтийг ашиглана. Чанарын үзүүлэлтийг тодорхойлохдоо 1) Асуулга, 2) Шууд ажиглалт, 3) Баримт бичгийн дүн шинжилгээ зэрэг мэдээллийг ашиглана. Чанарын үзүүлэлтийг дараах тохиолдлуудад ашиглах нь тохиромжтой.

- Ярвигтай нөхцөл байдлыг хам өгөгдөл (контекст дата)-өөр тайлбарлах,
- Тоон үзүүлэлтийн “яагаад”, “хэрхэн” гэх үндэслэлийн тайлбарыг нэмж оруулах,
- Тоон үзүүлэлтийн өгөгдөл нь бага, эсхүл богино хугацааны үнэлгээ, жишиг туршилтаар тоон үнэлгээ хийхэд хүндрэлтэй байсан,
- Төслийн явцад гарч болох санамсаргүй үр дүнгийн талаарх “дотоод мэдээлэл”-ийн өнцгийг тусгах,
- “Амьд дуу хоолой”-г тусгах,
- Чанарын үзүүлэлтийг ашиглахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.
- Нийтлэг бус шинжтэй байдаг,
- Ягштал биелүүлэхэд цаг хугацаа, зардал шаарддаг,
- Дүн шинжилгээ, тайлбар хийхэд хүндрэлтэй байдаг.

#### ④ **Тайлбар**

Шалгуур үзүүлэлтийг хэрхэн, хэзээ тооцох зэрэг бусад дэлгэрэнгүй тайлбарыг оруулна.

#### ⑤ **Суурь түвшин, өмнөх оны хэрэгжилтийн байдал**

Тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу нөхцөл байдал сайжирсан эсэх, өөрөөр хэлбэл төслийн өмнө ба дарааг харьцуулж, гүйцэтгэлийг нягтлахад төсөл эхлэх үеийн суурь үзүүлэлт шаардлагатай байдаг. Барилга угсралтын тухайд суурь үзүүлэлт нь ихэвчлэн 0 байх ба хүүчин барилгыг буулгах шаардлагатай бол энэ тухай товч тайлбарлана.

#### ⑥ **Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн**

– Жил бүрийн шалгуур үзүүлэлт  
УХОХ-ийн хүчинтэй хугацаа буюу 4 жилийн доторх жил бүрийн зорилтыг бичнэ. Зөвхөн бүтээн байгуулалтын үеийг тусгах ба бүтээн байгуулалт нь 10 жил үргэлжлэх байсан ч УХОХ-ийн харгалзах 4 жилийн зорилт, шалгуур үзүүлэлтийг дурдана.

– Эцсийн хүрэх түвшин  
Эцсийн хүрэх түвшин баганад 4 жилээр хязгаарлалгүй, бүтээн байгуулалтын хугацаа дууссаны дараах хүрэх түвшнийг тодорхой дурдана.

#### 1.3.5 **Урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл**

Тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай урьдчилсан судалгаа, газар чөлөөлөх зэрэг ажлын явцыг харуулна.

#### ① **Урьдчилсан судалгаа хийгдсэн байдал**

Тухайн төслийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн судалгаа тус бүрийн танилцуулга, тусгай тайлбарыг бичнэ. Судалгаа хийгдээгүй бол харгалзах хэсэгт судалгаа хийгээгүй

байгаа шалтгааныг эсвэл цаашид хийхээр төлөвлөсөн он сарыг бөглөнө. Судалгаа хийсэн бол судалгаа гүйцэтгэгчийн нэр, судалгаа хийсэн огноо, шинэчилсэн огноог дурдана.

② **Байгаль орчинд нөлөөлөх байдлын өрөнхий ба нарийвчилсан үнэлгээ**

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт, тусгай тайлбар, гүйцэтгэгчийн нэр, үнэлгээ хийсэн болон шинэчилсэн огноо, үнэлгээ хийгээгүй бол шалтгаан, цаашид хийхээр төлөвлөсөн он сарыг дурдана.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн эсэхээс үл хамааран тухайн төсөл байгальд ээлтэй технологи эсвэл удирдлага, үйл ажиллагааны арга хэрэгсэл нэвтрүүлж байгаа бол түүнийг дурдана. Үүнд байгаль орчны менежментийн арга хэрэгсэл (ногоон технологи, эко дизайн, байгаль орчны менежментийн тогтолцоо гэх мэт), эсвэл тэдгээртэй дүйцэхүйц технологи, уламжлалт арга барил зэрэг хамаарна. Мөн байгаль орчныг хамгаалах хариуцлагын хүрээнд ил тод байдлыг хангаж, талуудыг оролцуулсан уулзалт, асуулга, түүвэр судалгаа хийсэн эсэх талаар дурдана. Байгаль орчинд ямар нэгэн нөлөөлөлгүй төсөл бол энэ талаар тэмдэглэнэ.

③ **Газрын асуудал шийдэгдсэн эсэх**

Төслийг хэрэгжүүлэхэд газар чөлөөлөх, газар ашиглах эрх авах шаардлагатай бол тухайн ажлын явц, тусгай тайлбарыг оруулна. Газар чөлөөлөх шаардлагатай бөгөөд чөлөөлж дуусаагүй бол шалтгааныг тайлбар хэсэгт бичнэ. Үүнд: 1) Газар чөлөөлөлт хийгдээгүй үндсэн шалтгаан (жишээ нь: төсөл хэрэгжих байршлыг эцэслэн тогтоогоогүй, оршин суугчидтай зөвшилцөөгүй, санхүүжилт дутмаг гэх мэт), 2) Газар чөлөөлөлтийн явц (...% чөлөөлсөн гэх мэт), 3) Газар чөлөөлөлт дуусах хугацааг (жишээ нь: ... оны .. сар гэхэд чөлөөлж дуусна эсвэл ..%-ийг чөлөөлнө, одоогоор тодорхойгүй гэх мэт) дурдана.

Газар чөлөөлж дууссан бол гэрчилгээний дугаар, төрөл, олгосон огноо, дуусах хугацаа, олгосон албан тушаалтны мэдээллийг оруулна. Төслийн мэдээллийн санд газрын координатыг оруулах тул хэд хэдэн байршилд газар чөлөөлөх бол харгалзах хэсгийг нэмж бүх байршлын мэдээллийг оруулна.

④ **Тусгай зөвшөөрөл, бусад судалгаа, гэрээ, хэлцэл**

Төслийг хэрэгжүүлэхэд тусгай зөвшөөрөл авсан, тодорхой судалгаа (инженер геодези, хөрс, усны эх үүсвэрийн гэх мэт судалгаа, шинжилгээ), эсвэл гэрээ хэлцэл (төслийн хүрээнд хийгдсэн хэрэгжүүлэгч, гүйцэтгэгчээс бусад бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, түүхий эд худалдан авах, зөвлөх үйлчилгээ, судалгаа гүйцэтгүүлэх гэрээ, хэлцэл) хийгдсэн бол тэдгээрийн өнөөгийн нөхцөл байдал, онцлох тайлбарыг тус бүрд нь тоочно.

Ялангуяа холбогдох зөвшөөрлийг аваагүй бол шалтгааныг харгалзах хэсэгт (жишээлбэл, цаашид тусгай зөвшөөрөл шаардлагагүй, ..оны ..сард авахаар төлөвлөсөн гэх мэтчилэн) тэмдэглэнэ.



Зураг 9. Төслийн урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл

7	Газрын асуудал шийдэгдсэн эсэх	Үгүй бол шалтгаан, тайлбар:	.....
		Тийм бол	Гэрчилгээний дугаар: Гэрчилгээний төрөл: а) эзэмших б) ашиглах в) өмчлөх Гэрчилгээ олгосон огноо: Он: .....Сар: .....Өдөр: ..... Гэрчилгээ дуусах огноо: Он: .....Сар: .....Өдөр: ..... Шийдвэр гаргасан: ③ Аймаг /нийслэл/: ..... Сум, дүүрэг: ..... Албан тушаал: ..... Нэр: .....
8	Холбогдох тусгай зөвшөөрлүүд:	Аваагүй бол шалтгаан, тайлбар:	.....
		Авсан бол:	Тусгай зөвшөөрлийн нэр: ..... /ашиглалтын лиценз, паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл в.м./ Тусгай зөвшөөрлийн дугаар: ..... Тусгай зөвшөөрөл олгосон огноо: .....
9	Бусад: /инженер, геологийн судалгаа, хөрсний шинжилгээ, усны шинжилгээ г.м. тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа. Хэдэн ч ажил байж болно./	а) Судалгаа, шинжилгээний ажлын нэр: ..... Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....	④
		б) Судалгаа, шинжилгээний ажлын нэр: ..... Гүйцэтгэсэн байгууллагын нэр: ..... Хийгдсэн огноо: ..... Нэмэлт өөрчлөлт хийсэн бол сүүлийн өөрчлөлтийн огноо: .....	
10	Байгуулсан гэрээ, хэлэлцээр: /Бүтээгдэхүүн борлуулалтын, тоног төхөөрөмж эсвэл түүхий эд материал нийлүүлэх, зөвлөх үйлчилгээний г.м. ямар нэг гэрээ, хэлэлцээр төслийн хүрээнд байгуулагдсан эсэх талаарх мэдээлэл/	а) Гэрээний төрөл: ..... /зөвлөх үйлчилгээний, барилга угсралтын, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн г.м./ Гэрээлэгч байгууллагын нэр: ..... Гэрээ хийгдсэн огноо: ..... Гэрээний хэрэгжилтийн өнөөгийн байдал: ..... Гэрээний үр дүн: .....	
		б) Гэрээний төрөл: ..... /зөвлөх үйлчилгээний, барилга угсралтын, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн г.м./ Гэрээлэгч байгууллагын нэр: ..... Гэрээ хийгдсэн огноо: ..... Гэрээний хэрэгжилтийн өнөөгийн байдал: ..... Гэрээний үр дүн: .....	

### 1.3.6 Дэд бүтэц

Тухайн төслийг хэрэгжүүлэхэд дэд бүтэц хэрэгцээтэй эсэх талаар дурдах ба дэд бүтцийг 9 төрөлд хуваасан. Хүснэгтэд дурдсанаас өөр дэд бүтэц шаардлагатай бол “бусад” гэсэн мөрөнд тохирох мэдээллийг бөглөнө.

Төслийн дэд бүтцийн хэрэгцээ							
Дэд бүтэц шаардлагатай эсэх: <input type="checkbox"/> ТНМ <input type="checkbox"/> ТҮГ							
№	Дэд бүтэц	Хэмжих нэгж	Нийт хэрэгцээ	Одоогийн байдал	Өргөтгөл/Шинээр барих	Техникийн нөхцөл авсан эсэх	Тайлбар
1	Эрчим хүчний хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	
2	Дулаан хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	
3	Ахуйн ус хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	
4	Технологийн ус хангамж					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	
5	Цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга		①	②	③	Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	⑤
6	Мэдээлэл, харилцаа холбоо					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	
7	Авто зам					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	
8	Төмөр зам					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	
9	Бусад					Аваагүй бол шалтгаан, тайлбар: Техникийн нөхцлийн дугаар: Техникийн нөхцлийн огноо:	

**① Нийт хэрэгцээ**

Бүтээн байгуулалт болон ашиглалтад орсноос хойших дэд бүтцийн хэрэгцээг тус тусад нь оруулна.

**② Одоогийн байдал**

УХОХ-т тусгахаар санал хүргүүлэх үед байгаа дэд бүтцийн талаар тайлбарлана. Нийт хүчин чадал ба төслийн хэрэгцээг хангах боломжит хүчин чадлыг тодорхой дурдана.

**③ Өргөтгөх/шинээр барих**

УХОХ-т тусгах төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны үе шатанд дэд бүтцийг өргөтгөх эсвэл шинээр барих шаардлагатай бол хүчин чадал, хэрэгжүүлэх төлөвлөгөөг дэлгэрэнгүй тайлбарлана. Тухайн дэд бүтэц нь баригдаж буй эсвэл баригдах төлөвлөгөөтэй бол холбогдох дэд бүтцийн төслийн нэрийг тайлбар баганад оруулна.

**④ Техникийн нөхцөл авсан эсэх**

Дэд бүтэц ашиглахад шаардагдах техникийн нөхцөл авсан бол дугаар, огноог, аваагүй бол шалтгаан, авахаар төлөвлөж буй хугацааг бөглөнө.

**⑤ Тайлбар**

Хэмжих нэгжийг, тухайлбал цахилгаан хангамжийн кВ/цаг, холоос татах бол цахилгаан шугамын уртыг км-ээр илэрхийлж, дэд бүтцийн хүчин чадал хүрэх боловч технологийн шинэчлэл хийх шаардлагатай гэх мэт бусад анхаарах зүйлийг дурдана.

**1.3.7 Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ**

Энэ хүснэгт нь тухайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг илэрхийлнэ.

Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ

(1) Нийгмийн ач холбогдол

1 Өөрөөс олон нийтэд үзүүлдэх үйлчилгээний стандартыг сайжруулахад нөлөөлөх үү?

Тайлбар:

②

2 Хүний эрүүл, урт удаан амьдрахад нөлөөлөх үү?

Тайлбар:

②

3 Иргэдийн мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлэхэд нөлөөлөх үү?

Тайлбар:

②

4 Иргэдийн эрүүл, аюулгүй, зохистой орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд нөлөөлөх үү?

Тайлбар:

②

5 Үндэсний үнэт зүйлийг хадгалах, хамгаалах, бий болгоход нөлөөлөх үү?

Тайлбар:

②

6 ЗУАТ-нд дурдагдсан нийгмийн ач холбогдлыг илтгэх үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангасан уу?

Тайлбар:

②

**Нийгмийн ач холбогдол**

① **Үнэлгээ**

Асуулгын дагуу ерөнхийд нь үнэлж “шууд хүчтэй чухал нөлөөтэй”, “шууд нөлөөтэй”, “шууд бус нөлөөтэй”, “тодорхойгүй эсхүл нөлөөгүй” гэдгийн аль нэгийг сонгоно.

② **Тайлбар**

Энэ хэсэгт сонгосон хариултын дэлгэрэнгүй тайлбар байна.

Зураг 12. Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ

(2) Эдийн засгийн үр ашиг

1 Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх үү?

Бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ	20-- он		20-- он		20-- он		20-- он		20-- он		Нийт	
	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн
				④								

Тайлбар:

⑦

2 Экспортыг дэмжих, импортыг орлоход нөлөөлөх үү?

③

Экспорт, импорт	Бүтээгдэхүүн	20-- он		20-- он		20-- он		20-- он		20-- он		Нийт	
		Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн
					⑤								

Тайлбар:

⑦

3 Ажлын байрыг нэмэгдүүлдэгд нөлөөлөх үү?

③

Бүтээн байгуулалтын үе шат

№	Мэргэжлийн чиглэл	Шууд ажлын байр				Шууд бус ажлын байр			
		Дотоод		Гадаад		Дотоод		Гадаад	
		T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2
1	Удирдах ажилтан								
2	Инженер технологийн ажилчид								
3	Мэргэжлийн ажилчид								
4	Бусад ажилчид								
	Нийт								

⑥

Үйл ажиллагааны үе шат

№	Мэргэжлийн чиглэл	Шууд ажлын байр				Шууд бус ажлын байр			
		Дотоод		Гадаад		Дотоод		Гадаад	
		T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2
1	Удирдах ажилтан								
2	Инженер технологийн ажилчид								
3	Мэргэжлийн ажилчид								
4	Бусад ажилчид								
	Нийт								

Тайлбар:

⑦

**Эдийн засгийн үр ашиг**

③ Үнэлгээ

Нийгмийн ач холбогдлын асуулгатай адил ерөнхийд нь үнэлж “шууд хүчтэй чухал нөлөөтэй”, “шууд нөлөөтэй”, “шууд бус нөлөөтэй”, “тодорхойгүй эсхүл нөлөөгүй” гэдгийн аль нэгийг сонгоно.

④ Үйлдвэрлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ

Дотоодын зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд борлуулалтын үнээр бус төслийн үр дүнд бий болсон нэмүү өртгийг тооцон, жил бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, мөнгөн дүнг тэмдэглэнэ.

⑤ Экспорт, импорт

Экспортод гаргах бүтээгдэхүүний хувьд төслийн үр дүнд бий болох үнэ цэнийг тооцно. Харин төсөл хэрэгжилтийн явцад импортлох бүтээгдэхүүний үнийг хасаж тооцох тул экспорт, импортын жил бүрийн хэмжээ, мөнгөн дүнг тус тусад нь оруулна.

⑥ Ажлын байр

– Мэргэжлийн чиглэл

Зарчмын хувьд хүснэгтэд дурдсан чиглэлээр хуваан бичих боловч төслийн төлөвлөгөөнд өөр нэр, ангилал ашигласан бол түүний дагуу өөрчилж болно. Ажлын байрыг шууд ба шууд бус гэж хуваана. Шууд ажлын байр гэдэг нь тухайн ААН-ийн бий болгосон ажлын байр буюу шууд цалин хөлс олгож буй, хөдөлмөрийн гэрээ байгуулсан байнгын ажилтан, эсвэл төслийн ажлын байранд тогтмол ажиллаж байгаа гэрээт ажилтныг хэлнэ. Шууд бус ажлын байр гэдэг нь тухайн ААН-тэй гэрээ байгуулан төслийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж буй туслан гүйцэтгэгч байгууллагын ажилтан, ажиллагсад, богино хугацааны гэрээ байгуулсан ажилтныг хэлнэ.

- Дотоод/гадаад ажиллах хүч

Ажиллах хүчийг иргөний харьяалал бус төслийг хэрэгжүүлэгч ААН-ийн харьяаллаар ангилна. Жишээ нь, гадаад улсын зөвлөх компанид харьяалагдаж буй Монгол хүн бол гадаад ажиллах хүч болно.

- T1/T2

Дээр дурдсан ангиллаас гадна төслийн хугацаанаас шалтгаалан T1 буюу төслийн бэлтгэл болон бүтээн байгуулалтын үе шатны ажлын байр, T2 буюу ашиглалтад орсноос хойших үеийн ажлын байр гэж хуваана. T1, T2 үе шатанд үргэлжлүүлэн ажиллаж буй ажилтан бол 2 үе шатанд давхардсан тоогоор оруулна.

#### ⑦ Тайлбар

Сонгох хариулт болон тоогоор илэрхийлэх боломжгүй боловч чухал ач холбогдолтой нэмэлт тайлбар, мэдээллийг багтаана.

Зураг 13. Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ

4 Иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх үү?

Бүтээн байгуулалтын үе шат

№	Мэргэжлийн чиглэл	Шууд ажлын байр				Шууд бус ажлын байр			
		Дотоод		Гадаад		Дотоод		Гадаад	
		T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2
1	Удирдах ажилтан								
2	Инженер технологийн ажилчид								
3	Мэргэжлийн ажилчид								
4	Бусад ажилчид								
	Нийт								

⑧

№	Мэргэжлийн чиглэл	Шууд ажлын байр				Шууд бус ажлын байр			
		Дотоод		Гадаад		Дотоод		Гадаад	
		T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2
1	Удирдах ажилтан								
2	Инженер технологийн ажилчид								
3	Мэргэжлийн ажилчид								
4	Бусад ажилчид								
	Нийт								

Тайлбар:

⑦

5 Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх үү?

Хөрөнгө оруулах объект	Төлөвлөж буй хөрөнгө оруулагч	20-- он		20-- он		20-- он		20-- он		20-- он		Нийт	
		Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн	Хэмжээ	Мөнгөн дүн

⑨

Тайлбар:

⑦

#### ⑧ Цалин, бодит орлого

Төсөл хэрэгжүүлснээр цалин, бодит орлого нэмэгдэхэд нөлөөлөх эсэхийг ажлын байртай адил загвараар он тус бүрээр бөглөнө.

#### ⑨ Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Төсөл хэрэгжүүлснээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах бол хөрөнгө оруулах объект, төлөвлөж буй хөрөнгө оруулагч, тоо хэмжээ, дүнг жил жилээр бичнэ.

### 1.3.8 Санхүү, эдийн засгийн шинжилгээ

Төслийн санхүү, эдийн засгийн шинжилгээ нь эдийн засаг, санхүү, орчин нөхцөл зэрэг олон талаас төслийн ач холбогдол, хэрэгжих боломжийг тоон үзүүлэлтээр үнэлж гаргадаг.

Санхүүгийн болон эдийн засгийн шинжилгээгээр өгөөжийн дотоод хувь, цэвэр өнөөгийн үнэ цэн, үр ашиг-зардлын харьцааг тооцно. Эдгээр нэр томъёоны тайлбарыг дор дурдав.

#### **а. Санхүү, эдийн засгийн шинжилгээнд ашиглах нэр томъёоны тайлбар**

Өгөөжийн дотоод хувь (ӨДХ:IRR): Төслийг эдийн засаг, санхүүгийн хувьд үнэлэх тоон үзүүлэлт юм. "Дотоод" гэдэг нь анхны оруулсан хөрөнгийн өсөлт буюу ашгийн хувийг жил бүрээр хөндлөнгийн параметргүйгээр тооцохыг хэлнэ. Мөн ӨДХ-ийг улсын эдийн засагт баялгийг үр ашигтай, тэнцвэртэй хуваарилахад ашигладаг эдийн засгийн ӨДХ (ЭЗӨДХ:EIRR:Economic Internal Rate of Return), тухайн төслийг хэрэгжүүлэгч байгууллагад өгөх санхүүгийн өгөөжийг илэрхийлдэг санхүүгийн ӨДХ (СӨДХ:FIRR:Financial Internal Rate of Return) гэж хуваана.

Цэвэр өнөөгийн үнэ цэн (ЦӨҮЦ:NPV): ӨДХ-тай адил төслийн эдийн засаг, санхүүгийн үнэлгээнд ашиглагддаг тоон үзүүлэлт бөгөөд төсөл хэрэгжсэнээр улсын эдийн засгийн үнэ цэн хэдий хэр нэмэгдэхийг илэрхийлдэг. ЦӨҮЦ тэгтэй тэнцүү байх хорогдуулалтын хувь хэмжээ нь ӨДХ болно.

Үр ашиг-зардлын харьцаа (ҮАЗХ:В/С): Төслийн нийт хугацаан дахь үр ашиг - зардлын харьцаа бөгөөд  $V/C > 1$  буюу үр ашиг зардлаас их байх тохиолдолд хөрөнгө оруулалт хийх нь ашигтай гэж тооцно.

Санхүүгийн өгөөж: Өгөөжийн дотоод хувь тооцоход ашигладаг санхүүгийн өгөөж гэж хөрөнгө оруулалтаар олж болох ашиг (цэвэр ашгийг нэмэгдүүлэх хэмжээ бөгөөд тодорхой хугацаан дахь хөрөнгийн өсөлт, өр зээлийн бууралттай тэнцэх мөнгөн дүн)-ийг хэлнэ. Тухайлбал, хөрөнгө оруулалт хийгдсэнээр бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрөөр олох орлого юм.

Эдийн засгийн өгөөж: ДНБ-ийг нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл "төслөөр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх эсвэл ашиглах үнэ цэн" ба "төслөөр хэмнэгдсэн зардлын үнэ цэн" гэж хуваан, мөнгөн дүнд хөрвүүлэн тооцсоныг хэлнэ.

Санхүүгийн зардал: Өгөөжийн дотоод хувь тооцоход ашиглах санхүүгийн зардал гэдэг нь цэвэр ашгийг бууруулах хэмжээ бөгөөд тодорхой хугацаанд хорогдсон хөрөнгө, нэмэгдсэн өр зээлтэй дүйцэх мөнгөн дүн юм. Тухайлбал, улсын хөрөнгө оруулалт хийхэд шаардагдах зардал буюу бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход зарцуулсан бүтээн байгуулалт, засвар, үйлчилгээний зардал, нөөцийг хорогдуулахгүй шилжих зүйлс (албан татвар, хүү, нөхөн төлбөр, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх зардал гэх мэт), үнийн өсөлтийн болзошгүй зардал зэрэг багтана.

Эдийн засгийн зардал. ДНБ-ийг хорогдох хэмжээ бөгөөд баялгийн нэмэгдэх, хорогдоход шууд нөлөөлөхгүй шилжих зүйлсийн зардлууд болон үнийн өсөлтийн болзошгүй зардал зэрэг нь эдийн засгийн зардалд орохгүй. Харин санхүүгийн зардалд хамаарахгүй боловч гадаад зах зээлээр дамжихгүйгээр ДНБ буурахад нөлөөлөх биет бус зардлыг эдийн засгийн зардал гэж тооцно. Жишээлбэл байгаль орчны доройтлоос үүдэн газар тариалангийн ургац багассан бол багассан хэмжээг эдийн засгийн зардал болгон эдийн засгийн өгөөжийн дотоод хувийг тооцоход ашиглана.

#### **б. Санхүүгийн шинжилгээ, эдийн засгийн шинжилгээний ялгаа**

Санхүүгийн шинжилгээ нь хэрэгжүүлэгч байгууллага өөрийн өнцгөөс төслийг хэрэгжүүлэх санхүүгийн боломжийг шинжлэх зорилготой бөгөөд санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх нэг нөхцөл болдог. Харин эдийн засгийн шинжилгээ нь тухайн төсөл хязгаарлагдмал баялгийг үр ашигтай хуваарилж чадахыг батлан харуулах зорилготой бөгөөд хөрөнгө оруулалт улсад ашиг өгч, иргэдийн амьдралын чанарыг сайжруулах ач холбогдолтой гэдгийг тоон үзүүлэлтээр харуулна.

Санхүүгийн шинжилгээ, эдийн засгийн шинжилгээний тус бүрийн онцлогийг дараах хүснэгтэд дурдав.

Хүснэгт 2. Эдийн засгийн шинжилгээ, санхүүгийн шинжилгээний онцлов

	Эдийн засгийн шинжилгээ	Санхүүгийн шинжилгээ
Зорилго	Улс орны эдийн засгийн чадавхыг үнэлэх	Зардлыг нөхөх мөнгөн урсгалыг бий болгох санхүүгийн чадавхыг үнэлэх
Субъект	Улс орон болон түүний иргэд	Хэрэгжүүлэгч байгууллага (Хөрөнгө оруулагч, Үйлдвэрийн эзэн)
Үзүүлэлт	"Сүүдрийн үнэ (shadow prices)" буюу эдийн засгийн үнэд суурилсан	Зах зээлийн үнэд суурилсан
Үнэлгээ	Үнийн гажуудал ба зах зээлийн бус нөлөөллөөс үүсдэг Эдийн засгийн ач холбогдол	Санхүүгийн ач холбогдол
Аргууд	Өнөөгийн цэвэр үнэ цэн (NPV), Өгөөжийн дотоод хувь (эдийн засгийн өгөөжийн дотоод хувь) (IRR) (EIRR), Үр ашиг - зардлын харьцаа (B/C) гэх мэт.	Хорогдуулсан мөнгөн урсгалын арга (DCF), Өгөөжийн дотоод хувь IRR (Санхүүгийн өгөөжийн дотоод хувь - FIRR), Эргэх төлөх хугацаа (Payback Period), Бодит сонголтуудын үнэ цэн (Real Options Value or ROA) гэх мэт.
Өгөөжийн дотоодын хувийн босго	Нийгмийн хорогдуулалтын хувь (Social discount rate)	Урт хугацаат хүүгийн түвшин

Түүнчлэн ЦӨҮЦ, үр ашиг-зардлын харьцааг ямар ч төслийн хувьд тооцож болдог бол СӨДХ, ЭЗӨДХ-ийн тухайд төслийн онцлогоос хамаарч СӨДХ, ЭЗӨДХ тооцох буюу эдийн засаг, санхүүгийн шинжилгээг аль алийг нь хийх, зөвхөн ЭЗӨДХ-ийг тооцох буюу зөвхөн эдийн засгийн шинжилгээ хийх, СӨДХ, ЭЗӨДХ аль алийг нь тооцох боломжгүй байх тохиолдол байдаг.

#### (1) СӨДХ, ЭЗӨДХ тооцох

Хэрэглэгчээс ашиглалтын төлбөр авах төсөл нь СӨДХ, ЭЗӨДХ-ийг тооцох боломжтой байдаг. Жишээлбэл, төлбөртэй зам, төмөр зам, боомт, нисэх буудал, цахилгаан станц, усан хангамж, ариутгах татуурга зэрэг болно.

#### (2) Зөвхөн ЭЗӨДХ тооцох

Ашиглалтын төлбөр авахад хүндрэлтэй эсвэл боломжгүй төслүүдийн хувьд зөвхөн ЭЗӨДХ-ийг тооцох буюу эдийн засгийн шинжилгээ хийнэ. Төлбөртэй замаас бусад авто зам, гамшгаас урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төслүүд байж болно. Зөвхөн ЭЗӨДХ-ийг тооцох зарим төслийн хувьд өгөөжийг тоон үзүүлэлтээр илэрхийлэхэд хүндрэлтэй байдаг. Энэ тохиолдолд тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, нийгмийн ач холбогдлын талаарх мэдээллийг цуглуулан, зардал, үр дүнгийн шинжилгээгээр төслийн хэрэгжилтийн үр дүн, үндэслэлийг тайлбарлах боломжтой.


#### (3) СӨДХ, ЭЗӨДХ тооцох боломжгүй төсөл

Жишээлбэл, ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл" гэх мэт дэд төслийг урьдчилан тодорхойлох боломжгүй, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих төсөл, арга хэмжээ нь УХОХ-т санал өгөх үед СӨДХ, ЭЗӨДХ тооцох боломжгүй байдаг.

#### 1) ЦӨҮЦ, ӨДХ-ийн онцлог

ЦӨҮЦ, ӨДХ тооцоход ирээдүйн орлого, зардлыг өнөөгийн үнэ цэнд хөрвүүлэх шаардлагатай болно. Өнөөгийн үнэ цэн гэдэг нь ирээдүйн үнэ цэнийн эсрэг ойлголт бөгөөд жишээлбэл, бэлэн 100 доллар байлаа гэж бодоход, хадгаламжийн нэг жилийн хүү 10 хувь бол жилийн дараа 110 доллар, 2 жилийн дараа 121 доллар болох ба энэ нь ирээдүйн үнэ цэн юм. Харин одоогоос 1 жилийн дараах мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо ирээдүйн үнэ цэнийг хадгаламжийн хүүд дараах томъёоны дагуу хувааж тооцдог. Бүдүүвчилбэл дараах байдлаар харагдана.

$$100 = \frac{110}{1 + 0.1} \quad 100 = \frac{121}{(1 + 0.1)^2}$$



Өнөөгийн үнэ цэнийг дараах томъёогоор илэрхийлнэ:

$$PV = \frac{FV}{(1 + r)^n}$$

PV (Present value) – Өнөөгийн үнэ цэн

FV (Future value) – Ирээдүйн үнэ цэн

Цэвэр өнөөгийн үнэ цэн нь дээрх ойлголтод тулгуурлан ирээдүйн мөнгөн урсгалыг өнөөгийн үнэ цэнд хөрвүүлнэ гэсэн үг бөгөөд дараах томъёогоор илэрхийлэгдэнэ:

$$NPV = -Investment + \frac{CF_1}{(1+r)^1} + \frac{CF_2}{(1+r)^2} + \dots + \frac{CF_N}{(1+r)^N}$$

CF (Cash Flow) – Мөнгөн урсгал

Энэ томъёоноос харахад ялангуяа эдийн засгийн шинжилгээнд ЦӨҮЦ "0"-ээс бага бол өнөөгийн үнэ цэнээр тооцсон хөрөнгө оруулалт нь үр ашгаас давсан байгаа тул тухайн төслийг хэрэгжүүлэхэд алдагдалтай, төслийг хэрэгжүүлэхгүй байх нь зүйтэй гэсэн шийдвэр гарна гэсэн үг. Гэвч ЦӨҮЦ тооцооллын сул тал нь том хэмжээний төслийн хувьд хөрөнгө оруулалт үр ашгаа өгч байгаа эсэхийг харах боломжоор хомс байдаг явдал.

Тиймээс ӨДХ-ийг тооцох нь чухал юм. ӨДХ гэдэг нь хөрөнгө оруулалтын дүн ирээдүйн үр өгөөжийг өнөөгийн үнэ цэнд хөрвүүлсэн мөнгөн урсгалтай таарч байх хувь (Rate) -ийг олох явдал бөгөөд дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

Энэ тооцооллын үр дүн нь ашгийн хувиар илэрхийлэгдэх хэдий ч төсөл хэрэгжүүлэх

$$Investment = \frac{CF_1}{(1+IRR)^1} + \frac{CF_2}{(1+IRR)^2} + \dots + \frac{CF_N}{(1+IRR)^N}$$

эсэх шийдвэр гаргахдаа СӨДХ бол энэ хувь санхүүжилтийн хүлээлтээс давж байвал хэрэгжүүлнэ, ЭЗӨДХ бол нийгмийн хорогдуулалтын хувиас их байвал төслийг хэрэгжүүлнэ гэсэн утга юм.

Гэсэн хэдий ч ӨДХ нь цар хэмжээг илэрхийлэхгүй тул төсвийн хязгаарлалт зэргийг тусгаж харуулахгүй, тэр утгаараа ижил ӨДХ-тай бол аль нэгийг сонгох боломжийг өгдөггүй сул талтай. Мөн ирээдүйд дахин хөрөнгө оруулалт хийж, мөнгөн урсгал хасах утгатай болох тохиолдолд тооцоолох боломжгүй байдаг.



Тиймээс эдийн засаг, санхүүгийн шинжилгээнд ЭЗӨДХ, ӨДХ-ийн онцлогийг сайтар ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах шаардлагатай байдгийг анхаарах хэрэгтэй юм.

### 1.3.9 Санхүүгийн шинжилгээ

Санхүүгийн шинжилгээ нь СӨДХ, ЦӨҮЦ, Үр ашиг-зардлын харьцааг тооцно. “Хавсралт 8. Санхүүгийн шинжилгээ” хүснэгтийг бөглөснөөр тооцоолж болох хэдий ч хүснэгтийг бөглөхийн тулд бүтээн байгуулалтын үе шатаас үйл ажиллагаа явуулах үе шат хүртэлх нийт орлогоос нийт зардлыг хассан цэвэр ашгийг он тус бүрээр тооцож гаргах хэрэгтэй. Үүний тулд дагалдах 4 дэд хүснэгт (8-1.Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал, 8-2. Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа, 8-3. Зардлын тооцоолол, 8-4. Орлогын тооцоолол) –ийг бөглөх шаардлагатай.

Эдгээр хүснэгтийг бөглөх дараалал нь эхлээд зардлын хэсгийг бөглөх буюу бүтээн байгуулалтын үеийн зардлыг “8-2. Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа” хүснэгтэд оруулж, “8-3. Зардлын тооцоолол” хүснэгтээр ашиглалт, засвар арчилгааны зардлыг тооцоолсны дараа нийт зардлын хүснэгт болох “8-1.Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал” –ыг гүйцээнэ. Дараа нь орлогын хэсэг буюу “8-4. Орлогын тооцоолол” хүснэгтээр орлогыг таамаглана. Үүний үндсэн дээр “8. Санхүүгийн шинжилгээ” хүснэгтэд цэвэр зардал, ашгийг тооцоолсноор ӨДХ, ЦӨҮЦ, Үр ашиг-зардлын харьцаа бодогдож гарахаар хүснэгтүүдийг боловсруулсан. Холбогдох хүснэгтүүдийг хэрхэн бөглөх, анхаарах зүйлс зэргийн дүүр тайлбарлав.

#### Зардлыг тооцох

Зардлын төрөл, гадаад, дотоод валют

Эдгээрийг бөглөхийн тулд эхлээд хүснэгтэд ашиглагдах зардлын төрлүүдийг ойлгох шаардлагатай. Эдгээр зардлын төрөл нь ЭЗӨДХ-ийг тооцоолох хүснэгтэд мөн адил байна.

Хүснэгт 3. Зардлын төрөл

	Зардлын төрөл	Агуулга
①	Тоног төхөөрөмжийн зардал (Material Cost, Equipment Cost)	Барилга угсралтын үеийн материал, тоног төхөөрөмж худалдан авах зардал
②	Хөдөлмөрийн хөлс (Labor Cost)	Мэргэжлийн болон мэргэжлийн бус ажиллах хүчний цалин хөлс
③	Газрын зардал (Land Acquisition Cost)	Төслийн хэрэгжилтэд шаардлагатай газрыг чөлөөлөх, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх зардал
④	Захиргааны нэмэлт зардал (Incremental Administration Cost)	Төсөл хэрэгжүүлэх, ашиглалт, засвар үйлчилгээнд шаардлагатай захиргааны нэмэлт зардал
⑤	Зөвлөх үйлчилгээний зардал (Consultant Cost)	Гадаад, дотоодын зөвлөхийн үйлчилгээний зардал
⑥	Татварын зардал (Tax, VAT)	Материал, тоног төхөөрөмжийн импортын татвар, төсөлд оролцогч зөвлөх болон гэрээт ААН-д ногдох хуулийн этгээдийн албан татвар
⑦	Ашиглалт, засвар, үйлчилгээний зардал (O&M Cost)	Засвар, үйлчилгээний зардал (Их засварын зардлыг шаардлагатай бол оруулна)
⑧	Барилга байгууламжийн болзошгүй зардал (Physical Contingency)	Бүтээн байгуулалтын үеийн зураг төсөл, техникийн нөхцөлийн өөрчлөлт гм төслийн нэмэгдэл зардал
⑨	Үнийн болзошгүй зардал, үнийн өсөлт (Price Contingency/Escalation)	Эхний хөрөнгө оруулалтаас хойших үнийн өсөлт
⑩	Үндсэн зардал (Base Cost)	① - ⑦ -гийн нийлбэр
⑪	Нийт зардал (Total Cost)	① - ⑨ -ийн нийлбэр

Мөн зардлыг дотоод валют (Local Currency: LC), гадаад валют (Foreign Currency: FC) –д хувааж тооцох ба хэрхэн хуваах, юуг анхаарах талаар дараах хүснэгтэд тайлбарлав.

Хүснэгт 4. Зардлын ангилал

Ангилал	Агуулга ба анхаарах зүйл
(1) Гадаад валют төгрөгийн альянаар тооцох ① Тоног төхөөрөмжийн зардал ⑤ Зөвлөх үйлчилгээний зардал ⑥ Татварын зардал	① Зарчмын хувьд олон улсын төндөрээр авах материал, тоног төхөөрөмжийг гадаад валютаар, дотоодоос авах боломжтой бөгөөд техникийн нөхцөл нь олон улсын түвшнийг хангасан зүйлсийн зардлыг төгрөгөөр тооцно. ⑤ Дотоод зөвлөхийн үйлчилгээг төгрөгөөр, гадаад зөвлөхийн үйлчилгээг гадаад валютаар тооцно. ⑥ Гадаад болон дотоод зөвлөхийн үйлчилгээг авах бол орлогын албан татварыг тус тус төгрөг болон гадаад валютаар тооцно.
(2) Зарчмын хувьд төгрөгөөр тооцох ② Цалин хөлс ③ Газар чөлөөлөх зардал ④ Захиргааны нэмэлт зардал	② Цалин хөлсийг мэргэжлийн болон мэргэжлийн бус гэж хуваан, ажиллах хүчний иргэншлээс үл хамааран харьяалагдаж буй ААН-ийн үндсэн үйл ажиллагаагаа явуулж буй улсаас шалтгаалан төгрөг эсвэл гадаад валютаар тооцно.

2) Бүтээн байгуулалтын үе шат дахь зардал

Бүтээн байгуулалтын үе шат дахь зардлыг тооцохдоо “8-2. Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа” хүснэгтийг ашиглан дараах байдлаар бөглөнө.

Зураг 14. Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа

Хавсралт. 8-2

Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа	
USD 1 =	MNT
USD 1 =	① JPY
MNT 1 =	JPY

Хийгдэх ажлууд	Төгрөг	Нийт
	MNT	MNT
Газрын зардал ②		0

Хийгдэх ажлууд	Нэгж	Хэмжээ	Нэгжийн үнэ		Зардал		Дүн
			Валют	Төгрөг	Валют	Төгрөг	
			USD	MNT	USD	MNT	
Багц 1: XXX ③	No.						
XXX1	No.						
XXX2 ④	km	⑤		⑥		⑦	⑧
XXX3	km						
...							
Маргаан шийдвэрлэх хороо	LS	1					
Нийт							

#### ① Валютын ханш

Бүтээн байгуулалтын үед гадаад улсаас бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах үед ашиглах валютын ханш юм. Төслийн санал өгөхийн өмнөх сарын сүүлийн өдрийн ханш эсвэл ТЭЗҮ зэргийн тооцоололд ашигласан ханш байна. Хэд хэдэн валют хэрэглэгдэж буй тохиолдолд бүх гадаад валютыг америк долларт шилжүүлж тооцох тул бусад валютын ам.доллартой харьцах ханшийг ч урьдчилан тооцно.

#### ② Газрын зардал

Газар чөлөөлөх зардлыг барилга угсралтын зардлаас тусад нь тооцно. Үүнтэй холбогдох бусад зардал буюу оршин суугчдад тайлбарлан таниулах хурлын зардал, холбогдох төлбөр, хураамж, татвар зэргийг оруулан тооцно.

③ **Багц**

Төсөл нь хэд хэдэн бүрэлдэхүүн хэсгээс бүтэж буй бол тооцоолол хийх үед бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр хуваан тооцоолох ба багц тус бүрийн хийгдэх ажил, хэмжээ, хэмжих нэгж, нэгж үнийг тооцон, хийгдэх ажил тус бүрээр нийт дүнг гаргана.

④ **Хийгдэх ажил**

Дээр дурдсан 1) Зардлын төрөл, гадаад, дотоод валют хэсэгт заасныг үндэслэн худалдан авах материал, тоног төхөөрөмжийн нэрийг (хоолой, асфальт, цөмөнт гэх мэт) дурдана. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн хувьд "Маргаан шийдвэрлэх хороо" (Dispute Board: DB) байгуулах бол түүнд шаардагдах зардлыг тусгана.

⑤ **Нэгж ба хэмжээ**

Хийгдэх ажилд тохирох нэгж, хэмжээг оноож, нэгж тус бүрд харгалзуулан ашиглахаар төлөвлөж буй хүчин чадлыг бичнэ.

⑥ **Нэгжийн үнэ**

Зах зээл дээр борлуулагддаг бараа бүтээгдэхүүний хувьд зах зээл дээрх нэгж үнэ байх ба 3-аас дээш нийлүүлэгчээс үнийн санал авч хамгийн бага үнийг бичнэ. Ганцхан нийлүүлэгч нийлүүлдэг бараа, бүтээгдэхүүн бол тухайн нийлүүлэгчийн үнийг, зах зээл дээр байхгүй бол зохистой үнийг тооцон тусгана.

Нийлүүлэгчийн бараа татах аргаас шалтгаалан дотооддоо худалдан авах боломжтой бараа бүтээгдэхүүний үнийг төгрөгөөр, гадаадаас авах шаардлагатай бараа бүтээгдэхүүний үнийг гадаад валютыг ам.долларт шилжүүлсэн дүнгээр бичнэ.

⑦ **Гадаад валют, төгрөг тус бүрийн нийт дүн**

Хийгдэх ажил тус бүрээр нэгж ба хэмжээ, гадаад валют, төгрөгөөр илэрхийлсэн нэгжийн үнийг үржүүлэн тооцоолно.

⑧ **Хөрвүүлсний дараах дүн ба нийт дүн**

Хийгдэх ажил тус бүрийн гадаад валютаар тооцсон дүнг төгрөгт шилжүүлж, төгрөгийн дүн дээр нэмнэ. Мөн бүх ажлын зардлын нийлбэрийг гаргаж багцын нийт дүнг тооцоолно.

Дээр дурдсан дарааллыг бүх багцад давтсанаар "8-2. Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа" хүснэгт бөглөгдөж дуусна.

(3) Ашиглалт, засвар үйлчилгээний үе шат дахь зардал

Ашиглалт, засвар үйлчилгээний зардлын тооцоог "8-3. Ашиглалт, засвар үйлчилгээний зардлын тооцоолол"-ын хүснэгтийг ашиглан хийх бөгөөд дор дурдсаны дагуу бөглөнө.

Зураг 15. Зардлын тооцоолол

Хавсралт. 8-3

**Зардлын тооцоолол**

Хугацаа	Ашиглалт, засвар үйлчилгээний зардал	Ашиглалт, засвар үйлчилгээний зардал	Ашиглалт, засвар үйлчилгээний зардал	Ашиглалт, засвар үйлчилгээний зардал
	Зардал 1	Зардал 2	Зардал 3	Нийт
2021				
2022				
2023				
2024			①	
2025				
2026				
2027				
2028				

① **Ашиглалт, засвар үйлчилгээний жил бүрийн нийт зардал**

Ашиглалт, засвар, үйлчилгээний зардлыг тооцоход дор тайлбарласнаар зардлын төрөл бүрээр тооцох (Аргачлал 1), нийт дүнгээр тооцох (Аргачлал 2) гэсэн арга байна. Аргачлал 1-ийн тухайд цалин хөлс, сэлбэг хэрэгслийн зардал, их засварын зардал зэргийг тооцох шаардлагатай. Энэ нь төсөл тус бүрд өөр байх тул зардал тус бүрээр оруулна. Аргачлал 2-ын хувьд нийт хөрөнгө оруулалтын дүнг "Нийт" гэсэн хэсэгт оруулах бөгөөд үйл ажиллагаа явуулж дуусахаар төлөвлөсөн хугацаа хүртэл жил бүрээр бөглөнө.

Зураг 16. Зардлын тооцоолол

Аргачлал 1

Хугацаа	Зардал 1		Зардал 2		Зардал 3	
	Тооцож буй хэмжээ	Үнэ	Тооцож буй хэмжээ	Үнэ	Тооцож буй хэмжээ	Үнэ
2021						
2022						
2023						
2024				②		
2025						
2026						
2027						

② **Ашиглалт, засвар үйлчилгээний шат дахь зардлыг төрөл тус бүрээр тооцоолох арга (Аргачлал 1)**

Ашиглалт, засвар үйлчилгээний шатан дахь зардлыг төрөл тус бүрээр тооцоолох аргыг хэрэглэхдээ тэдгээрийн тоо хэмжээ болон нэгж үнийг оруулна. Мөн тус аргыг хэрэглэх бол Аргачлал 2-ыг бөглөх шаардлагагүй.

Зураг 17. Зардлын тооцоолол

Аргачлал 2

Эхний жил=  
(Нийт хөрөнгө  
оруулалтын дүнгийн  
хувь)

2 дахь жилээс хойш  
зардал тооцох хувь=

③	%
Арифметик прогресс (II Пугаман)	

③ **Ашиглалт, засвар үйлчилгээний шатан дахь зардлыг нийт дүнгээр тооцоолох арга (Аргачлал 2)**

Ашиглалт, засвар үйлчилгээний үе шатан дахь зардлыг нийт дүнгээр тооцоолох Аргачлал 2-оор тооцоолохдоо нийт өртгийн хэдэн хувь болгохоо тогтоож, оруулна. Энэ аргаар тооцоолоход зардлын харьцаа хэд орчим хувь байхыг салбарын болон бусад судалгааны үр дүнгээр гаргасан үндэслэл бүхий хувийг хэрэглэнэ.

Түүнчлэн 2 дахь жилээс хойших зардлыг тооцохдоо харгалзах хэсэгт эхний жилээс эхлэн гарах болзошгүй зардлын өөрчлөлтийг тусгана. Тухайлбал, зардлыг тогтмол дүнгээр тооцох, зардлыг жил бүр тодорхой хувиар (арифметик прогресс) өсгөн тооцох, зардлыг жил бүр өсөн нэмэгдэх хувиар (геометр прогресс) тооцохын аль нэгийг сонгоно.

(4) Жил бүрийн хөрөнгө оруулалтын хүснэгтийг бөглөх

Дээр дурдсан тооцоолох хүснэгтэд үндэслэн бусад зардлыг оруулан, жил бүрийн шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг "8-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал" хүснэгтэд оруулна. Доорх хүснэгтэд шинээр оруулах шаардлагатай зардлыг тооцоолох аргыг үзүүлэв.

Зураг 18. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал

Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Санхүүгийн шинжилгээ)									
Хавсралт 8-1									
Параметр:	Зардлын тооцооны гууруу олоо:			1-р сар 2021			2020		
	Зардлын тооцооны гууруу олоо:	1-р сар 2021	2020	Валют:	оая. ам.доллар		Валют:	оая. ам.доллар	
	Валютын ханш 1:	USD = MNT		Төгрөг:	оая. төгрөг		Төгрөг:	оая. төгрөг	
	Валютын ханш 2:	USD = JPY							
	Валютын ханш 3:	MNT = JPY							
	Үнийн өсөлт:	Валют: 1.72%	Төгрөг: 7.00%						
	Барилга, байгууламжийн болзошгүй зардал:	5.0%							
	Зөвлөх үйлчилгээний болзошгүй зардал:	5.0%							
	Зөвхөргөөний зардал =	4.0%							
	НӨАТ =	15.0%							
	Гаалийн татвар =	10.0%							
	Бусад татвар, хураамж =	0.0%							
Төслийн хүрээнд хийгдэх ажлууд									
Нийт зардал									
2021									
2022									
2023									
Валют Төгрөг Нийт Валют Төгрөг Нийт Валют Төгрөг Нийт Валют Төгрөг Нийт									
<b>A. Бүрэлдэхүүн</b>									
I) Худалдан авалт / Барилга, байгууламж									
Багц 1:XXX									
Багц 2:XXX									
Багц 3:XXX									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
II) Зөвлөх үйлчилгээ									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
Нийт (I+II)									
<b>B. Бүрэлдэхүүн</b>									
a. Худалдан авалт / Барилга, байгууламж									
Багц 1:XXX									
Багц 2:XXX									
Багц 3:XXX									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
b. Газрын зардал									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
c. Зөвхөргөөний зардал									
d. Татвар									
НӨАТ									
Гаалийн татвар									
Бусад татвар, хураамж									
Нийт (a+b+c+d)									
НИЙТ (A+B)									
<b>C. Бүтээн байгуулалтын шатны хүүгийн зардал</b>									
Бүтээн байгуулалтын шатны хүүгийн зардал (Барилга, байгууламж)									
Бүтээн байгуулалтын шатны хүүгийн зардал (Зөвлөх үйлчилгээ)									
<b>D. Үйлчилгээний зардал</b>									
НИЙТ ДҮН (A+B+C+D)									

① Гадаад орчны өөрчлөлтийн зардлын тооцоо

Багц бүрийн жил бүр гарах зардал болон ашиглалт, засвар үйлчилгээний зардлын тухайд "8-2. Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа", "8-3. Ашиглалт, засвар үйлчилгээний зардлын тооцоолол" хүснэгтээс бөглөгдөж, "Үндсэн өртөг" дээр нэгтгэнэ.

Мөн гадаад орчны өөрчлөлтийн зардлын хуримтлал болгож үнийн өсөлт болон болзошгүй зардлыг (тус бүрийн тодорхойлолтыг "1) Зардлын төрөл, дотоод, гадаад валют" хэсгээс харна уу) тооцоолон оруулна.

② Татварын зардал

Дээр дурдсан бараа, ажил үйлчилгээний гаалийн татвар, хураамжийн зардлыг оиролцоо дүнгээр тооцно. Энд НӨАТ, экспорт, импортын татварыг жишээ болгон оруулсан ба бусад татвар, хураамжийн зардал гарахаар бол нэмж оруулна.

③ Зээлийн хүүгийн төлбөр

Төсөл зээлийн санхүүжилтээр хэрэгжих бол хүүгийн төлбөрийг тооцоолж оруулна.

④ Жил бүрийн нийт зардал

Жил бүрийн нийт зардлын дүн нь дотоод, гадаад валют, нийт (төгрөгөөр илэрхийлэх) гэж ангилагдан тооцоологдоно.

2) Орлогын тооцоолол

Орлогын тооцооллыг "Хавсралт 8-4. Орлогын тооцоолол хүснэгт"-ийн дагуу боловсруулна.

Орлогын тооцоолол

Хугацаа	Орлогын тооцоолол	Орлогын тооцоолол	Орлогын тооцоолол	Орлогын тооцоолол
	Орлогын эх үүсвэр 1	Орлогын эх үүсвэр 2	Орлогын эх үүсвэр 3	Нийт орлого
2021				
2022				
2023				
2024			①	
2025				
2026				
2027				

Хүснэгтийг бөглөх аргыг дор дурдав.

① **Үйл ажиллагааны чиглэл бүрийн орлого**

Төслийн үйл ажиллагааны чиглэлээс хамаарч хураамжийн орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын орлого гэх мэт олон төрлийн орлого байж болно. Иймд орлогын төрөл тус бүрийг “Орлогын эх үүсвэр” хэсэгт оруулан, “Нийт орлого” хэсэгт нэгтгэнэ. Энд 3 төрлийн орлого оруулахаар хийсэн ба үйл ажиллагааны чиглэлээс хамаарч илүү олон орлогын эх үүсвэр байх тохиолдолд харгалзах хэсгийг нэмж, мэдээллээ оруулна. Орлого тус бүрээр жил бүрийн тооцоолсон дүнг оруулна.

Зураг 20. Орлогын тооцоолол

Хугацаа	Орлого 1		Орлого 2		Орлого 3	
	Тооцож буй хэмжээ	Үнэ	Тооцож буй хэмжээ	Үнэ	Тооцож буй хэмжээ	Үнэ
2021						
2022						
2023						
2024				②		
2025						
2026						
2027						

② **Жил бүрийн тоо хэмжээ болон нэгж үнэ**

Бүх төрлийн орлогын эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээлэл болгож нэгж үнэ болон тоо хэмжээний тооцсон дүнг оруулна.

3) Цэвэр баланс ба зардал үр ашгийн тооцоо

“8-1.Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал”, “8-2.Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа”, “8-3.Ашиглалт, засвар үйлчилгээний зардлын тооцоолол”, “8-4.Орлогын тооцоолол”-ыг ашиглан жил бүрийн орлого, зарлагын дүн бодогдсоноор жил бүрийн баланс тооцоологдоно. Санхүүгийн өгөөжийн дотоод хувийг тооцохдоо “Хавсралт 8.Санхүүгийн шинжилгээ” хүснэгтийг ашиглана.

Түүнчлэн ТЭЗҮ зэрэг бусад тооцоолсон дүн байвал дэд хүснэгтийг бөглөхгүй, шууд “Хавсралт 8.Санхүүгийн шинжилгээ” хүснэгтийг бөглөж болно.

## Санхүүгийн шинжилгээ

Параметр: ЦӨҮЦ-ийг тооцох хорогдуулалтын хувь:  ① %

Хугацаа	Хөрөнгө оруулалт	Ашиглалт, засвар үйлчилгээ	Нийт өртөг	Нийт орлого	Цэвэр орлого/ Алдагдал	Хорогдуулсан мөнгөн урсгал		
	Зардал	Зардал				Зардал	Орлого	Цэвэр орлого
2021								
2022								
2023								
20....		②			③		④	
20....								
2056								
Нийт	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн өгөөжийн дотоод хувь

Үр ашиг, зардлын харьцаа

сөдх:	ЦӨҮЦ (сая төг):	0.00
ҮАЗХ:	⑤	

## ① ЦӨҮЦ-ийг тооцох хорогдуулалтын хувь

ЦӨҮЦ-ийг тооцохын тулд хорогдуулалтын хувийг тогтоох шаардлагатай ба энэ нь эх үүсвэрээс хамааран ялгаатай байна. Хөрөнгө оруулагчийн хүлээж буй өгөөж өндөр байвал үнэ цэнийн утга ч мөн өндөр байна. Зарчмын хувьд Улсын төсөв <Гадаадын зээл, тусламж >Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт гэсэн дарааллаар илүү өндөр түвшин шаардагдах боловч тухайн салбар, төслийн онцлогоос хамаарч ТЭЗ хорогдуулалтын хувийг тогтооно.

## ② Хөрөнгө оруулалт, ашиглалт, засвар үйлчилгээ, орлогын мөнгөн урсгал

Хөрөнгө оруулалт, ашиглалт, засвар үйлчилгээний мөнгөн урсгалын тухайд "8-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал" хүснэгтээс жил бүрийн нийт зардал, "8-4. Орлогын тооцоолол" хүснэгтээс жил бүрийн нийт орлогыг оруулна.

## ③ Жил бүрийн цэвэр мөнгөн урсгал

Жил бүрийн нийт орлогоос нийт зардлыг хасан, жил бүрийн цэвэр орлогыг тооцож гаргана.

## ④ Хорогдуулсан мөнгөн урсгал

Хорогдуулсан мөнгөн урсгал нь ЦӨҮЦ-ийг тооцоход шаардлагатай. ①-т тогтоосон хорогдуулалтын хувийг ашиглан нийт зардал, нийт орлого, цэвэр орлого тус бүрийг:  $n$  жилийн мөнгөн урсгалыг  $(1+Discount\ rate)^{n-1}$ -д хуваан тооцно.

## ⑤ Төрөл бүрийн үзүүлэлтүүдийг тооцоолох

Мөнгөн урсгалын бүх хэсгийг бөглөснөөр СӨДХ, ЦӨҮЦ болон ҮАЗХ нь урьдчилан өгөгдсөн томъёогоор бодогдон гарч ирнэ.

## 1.3.10 Эдийн засгийн шинжилгээ

Эдийн засгийн шинжилгээний хүснэгт нь эдийн засгийн өгөөжийн дотоод хувь (EIRR), эдийн засгийн цэвэр өнөөгийн үнэ цэн (NPV), үр ашиг-зардлын харьцаа (B/C) зэргийг тодорхойлох зорилготой. Үүнийг Хавсралт 9. Эдийн засгийн шинжилгээ"-г бөглөснөөр тодорхойлох боломжтой боловч бүтээн байгуулалтаас ашиглалтын үе шат хүртэлх нийт эдийн засгийн үр ашгаас нийт зардлыг хасаж, цэвэр үр ашгийг тооцох хэрэгтэй болно. Эдийн засгийн үнэ цэнд хөрвүүлсэн зардлын дийлэнх нь санхүүгийн шинжилгээнд ашиглагдсан зардалд үндэслэнэ. Дээрх тооцоололд дөхөм болох үүднээс Хавсралт 9-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал", Хавсралт 9-2. Үр ашгийн тооцоолол" гэсэн

хоёр дэд хүснэгтийг нэмж оруулсан бөгөөд эдгээр хүснэгтийг бүрэн бөглөх нь бодитой үр дүн гарах үндэс болно. Мөн санхүүгийн зардал, үр ашгийн утгыг эдийн засгийн үнэ цэнд шилжүүлэхэд стандарт хөрвүүлгийн факторыг ашигладаг ба энэ нь улсын хэмжээнд ижилхэн нэг үзүүлэлтийг ашиглах боломжтой байдал тул Монгол Улсын стандарт хөрвүүлгийн факторыг "9. Эдийн засгийн шинжилгээ" хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгтийг бөглөх дарааллын хувьд, эхлээд нийт шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлыг "9-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал"- хүснэгтийн дагуу гүйцээн бөглөнө. Дараа нь боломжит үр ашгийг "9-2. Үр ашгийн тооцоолол" -ын дагуу тооцож гаргана. Эдгээр дэд хүснэгтийг ашиглан "Хавсралт 9. Эдийн засгийн шинжилгээ" дээрх цэвэр үр ашгийг тооцон гаргаснаар ЭЗӨДХ, ЦӨҮЦ, үр ашиг, зардлын харьцааны үр дүн тодорхойлогдоно.

Дээрх хүснэгтийг хэрхэн бөглөх, юунд анхаарах талаар дор дэлгэрэнгүй дурдлаа.

1) Санхүүгийн зардлыг эдийн засгийн зардалд хөрвүүлэх

ЭЗӨДХ-ийг тооцоход ашиглагдаж буй зардал нь санхүүгийн шинжилгээнд дурдагдаж буй бодит зардал бус, эдийн засгийн үнэ цэнд хөрвүүлсэн зардал юм. Эдийн засгийн зардлыг дор дурдсан дарааллын дагуу тооцно.

(1) Биет ба биет бус зардлыг тодорхойлох

Төслийн эдийн засгийн зардлыг тооцохдоо бодит зардал буюу "биет зардал", санхүүгийн тайланд тусгах боломжгүй, нийт үндэсний баялгийн хорогдол буюу "биет бус зардал"-ыг тодорхойлохоос эхэлнэ.

(2) Биет зардлыг ангилах (Шилжих зүйлсийг тодорхойлох)

Биет зардал нь нөөц (баялаг)-ийн бодит хорогдлыг илэрхийлэх "Бодит зардлын зүйлс" болон нийт нийгэм, эдийн засгийн үүднээс харахад нөөцийн хорогдлыг үүсгэхгүй "Шилжих зүйлс", "Болзошгүй зардал" гэсэн ангилалд хуваагдана. Шилжих зүйлс болон болзошгүй зардал нь нөөцийг хорогдуулахгүй тул эдийн засгийн зардлаас хасаж тооцдог.

(3) Бодит зардлын зүйлсийг ангилах (Худалдааны болон худалдааны бус барааг ангилах)

Бодит зардлын зүйлс нь экспорт, импорт зэргээр олон улсын түвшинд арилжаалагдах "Худалдааны бараа, ажил үйлчилгээ" (Tradable Goods and Service TGS) болон зөвхөн нэг улсын дотоодод арилжаалагдах "Худалдааны бус бараа, ажил үйлчилгээ" (Non-Tradable Goods and Service NTGS) гэж ангилагддаг. Гэвч ийнхүү ангилах нь ихэнхдээ хүндрэлтэй байдаг тул хялбарчлан гадаад валют болон дотоод валют гэсэн ангиллаар тооцохоор тусгасан.

(4) Зардлыг эдийн засгийн үнэ цэнд хөрвүүлэх

Худалдааны бараа, ажил үйлчилгээний үнийг хил дээрх үнээр тооцох боломжтой байдаг ба тээвэрлэлт, даатгал зэрэг холбогдох зардал (CIF Cost, Insurance and Freight)-ыг шингээн, эдийн засгийн зардлын дүнг тооцно. Ингэхдээ гадаад валютын зардал (татваргүй)-тай адилтган үзэх нь түгээмэл байдаг.

Худалдааны бус ажил, үйлчилгээний хувьд зах зээлийн үнийн гажуудлыг арилгах шаардлагатай байдаг бөгөөд ихэвчлэн стандарт хөрвүүлгийн фактор (SCF)-ыг ашиглан эдийн засгийн үнэ (татваргүй)-д хөрвүүлдэг.

Хүснэгт 9-1-ийг хэрхэн бөглөх талаар Зураг 23-т харуулан дор тайлбарлав.

① **Дотоод валютаар илэрхийлэгдсэн зардлыг эдийн засгийн зардалд хөрвүүлэх**

Дээр дурдсанчлан төгрөгөөр илэрхийлэгдсэн худалдааны бус зардлыг эдийн засгийн үнэ рүү хөрвүүлэхдээ санхүүгийн шинжилгээгээр тодорхой болсон зардлыг стандарт хөрвүүлгийн фактораар үржүүлж гаргана. Гэхдээ газрын хувьд зах зээлийн эргэлтэд орсон гэж үзэж буй бол зах зээл дээрх арилжаалагдаж буй үнийг эдийн засгийн зардал гэж тооцно.



② **Болзошгүй зардал**

Эдийн засгийн тооцоололд инфляцийн нөлөөг арилгадаг учир "0" гэж тооцно.

③ **Нөөцийн ашиглалт, хорогдлыг бий болгохгүй санхүүгийн зардал**

Санхүүгийн зардлын дотор нөөцийн хорогдлыг бий болгохгүй хүү, татаас, газар чөлөөлөлтийн нөхөн төлбөр гэх мэт зардлыг эдийн засгийн тооцоололд зардал гэж үзэхгүй бөгөөд "0" гэж тооцно.

Зураг 22. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Эдийн засгийн шинжилгээ)

Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Эдийн засгийн шинжилгээ)

Параметр:

Зардлын тооцооны суурь он/сар:	1-р сар 2021	Валют:	сая. ам.доллар
Валютын ханш 1:	USD = MNT 2620	Төгрөг:	сая. төгрөг
Валютын ханш 2:	USD = JPY		
Валютын ханш 3:	MNT = JPY	SCF=	0.89483
Үнийн өсөлт:	Валют: 1.72% Төгрөг: 7.00%	Стандарт хөрвүүлгийн фактор	
Барилга, байгууламжийн болзошгүй зардал:	5.0%		
Зөвлөх үйлчилгээний болзошгүй зардал:	5.0%		
Захиргааны зардал =	4.0%		
НӨАТ =	18.0%		
Гаалийн татвар =	10.0%		
Бусад татвар, хураамж =	0.0%		

Төслийн хүрээнд хийгдэх ажлууд	Нийт зардал		2021			2022			
	Валют	Төгрөг	Нийт	Валют	Төгрөг	Нийт	Валют	Төгрөг	Нийт
<b>A. Бүрэлдэхүүн</b>									
I) Худалдан авалт / Барилга, байгууламж									
Багц 1:XXX									
Багц 2:XXX									
Багц 3:XXX									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
II) Зөвлөх үйлчилгээ									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
Нийт (I+II)									
<b>B. Бүрэлдэхүүн</b>									
a) Худалдан авалт / Барилга, байгууламж									
Багц 1:XXX									
Багц 2:XXX									
Багц 3:XXX									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
b) Газрын зардал									
Үндсэн өртөг									
Үнийн өсөлт									
Болзошгүй зардал									
c) Захиргааны зардал									
d) Татвар									
НӨАТ									
Гаалийн татвар									
Бусад татвар, хураамж									
Нийт (a+b+c+d)									
<b>НИЙТ (A+B)</b>									
<b>C. Бүтээн байгуулалтын шатны хүүгийн зардал</b>									
Бүтээн байгуулалтын шатны хүүгийн зардал (Барилга, байгууламж)									
Бүтээн байгуулалтын шатны хүүгийн зардал (Зөвлөх үйлчилгээ)									
<b>D. Урьдчилгаа зардал</b>									
<b>НИЙТ ДҮН (A+B+C+D)</b>									

2) Эдийн засгийн үр ашгийн тооцоолол

Эдийн засгийн шинжилгээ нь нийт улсын эдийн засагт баялаг (ДНБ) бүтээгдэж байгаа эсэхийг хэмжих зорилготой тул үр ашиг гэж санхүүгийн шинжилгээний орлого бус эдийн засгийн үр ашгийг тооцож гаргасан дүн юм. Хэрхэн тооцох дарааллыг дор тайлбарлалаа.

(1) Үр ашигт тооцогдох зүйлсийг тодорхойлох

Эдийн засгийн үр ашиг нь “Төслийн хүрээнд шинээр бий болох бараа, үйлчилгээ, түүний ашиглалтын үнэ цэн” болон “Төслийн хүрээнд бий болсон зардлын хэмнэлт” гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваагдах ба эдгээрийг мөнгөн дүнд шилжүүлж тооцдог.

Үр ашигт тооцогдох зүйлс нь тухайн төслийн онцлогоос хамаарч харилцан адилгүй байдаг. Дараах хүснэгтэд зарим салбарын үр ашигт тооцогддог болон тооцогддоггүй үр ашгийн жишээг үзүүлээ.

Хүснэгт 5. Салбарын үр ашиг тооцох

Салбар	Тоон байдлаар хэмжигдэх үр ашиг	Үр ашигт тооцогдох нөлөөллүүд	Үр ашигт тооцоход хүндрэлтэй нөлөөллүүд
Хот тээвэр/зам	Тээврийн хэрэгслийн ашиглалтын зардал (VOC), Зорчих хугацааны зардал (TTC)-ын хэмнэлт	Зам тээврийн ослын бууралт, Байгаль орчныг бохирдуулагч бодисын бууралт, Тээврээс үүдэлтэй үр ашиг	Зорчих тав тух, аюулгүй байдал, хүртээмж сайжрах
Төмөр зам	Тээврийн хэрэгслийн ашиглалтын болон Зорчих хугацааны зардлын хэмнэлт	Зам тээврийн ослын бууралт, Байгаль орчныг бохирдуулагч бодисын бууралт, Тээврээс үүдэлтэй үр ашиг	Зорчих тав тух, аюулгүй байдал, хүртээмж сайжрах
Боомт	Тээвэрлэлтийн зардал болон Зорчих хугацааны зардлын хэмнэлт	Зам тээврийн ослын бууралт Байгаль орчныг бохирдуулагч бодисын бууралт Тээврээс үүдэлтэй үр ашиг	Зорчих тав тух сайжрах
Нисэх буудал	Тээвэрлэлтийн зардал болон Зорчих хугацааны зардлын хэмнэлт	Аюулгүй байдал сайжрах Тээврээс үүдэлтэй үр ашиг	Зорчих тав тух сайжрах
Усан хангамж	Зардлын хэмнэлт (Цэвэр усны шугам хувиараа татах зардал, ус алдсанаас үүсэх зардал г.м) Төлбөр төлөх бэлэн байдал(WTP) сайжрах	Байгаль орчны нөлөөллийг бууруулах Эмчилгээний зардлыг бууруулах Үйлдвэрлэлийг дэмжих (аялал жуулчлал г.м)	Тав тух сайжрах
Бохир ус	Ариутгах татуурга, ариутгах татуургын системийн өртөг буурах Цэвэрлэсэн усыг дахин ашиглах	Усан хангамжийн зардал Хөдөө аж ахуй, загас агнуурын үйлдвэрлэлийн өсөлт Байгаль орчныг бохирдуулагч бодисын бууралт	Тав тух сайжрах

Гүний ус	Зардал буурах (ус татах хугацааг багасгах, одоо байгаа худгийн өртөг) Төлбөр төлөх бэлэн байдал(WTP) сайжрах	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлт Эмчилгээний зардлыг бууруулах	Тав тух сайжрах
Хатуу хог хаягдал	Хог хаягдлыг ачих зардлыг бууруулах Хаягдлыг ашиглаж үнэ цэн бий болгох (дахин боловсруулах, ялзмаг бордоо үйлдвэрлэх г.м)	Байгаль орчны нөлөөллийг бууруулах Нийгмийн эрүүл мэндийг сайжруулах Эмчилгээний зардлыг бууруулах Байгаль орчныг бохирдуулагч бодисын бууралт	Хог хаягдлын талаарх мэдээлэлтэй болох, Тав тух сайжрах
Үерийн болон элсний нүүдлээс хамгаалах далан	Ирээдүйд тооцоолсон хохирлоос зайлсхийх	Хохирлыг бууруулах Байгаль орчны нөлөөллийг бууруулах	Аюулгүй байдал
Аялал жуулчлал	Аялал жуулчлалын салбарын ДНБ-ий өсөлт	Тухайн орон нутгийн дэд бүтэц сайжрах	Тухайн орон нутгийн ижилшил ба ондоошил илүү тодрох
Боловсрол		Нийгэм дэх бүтээмж сайжрах (насан туршийн цалин нэмэгдэх)	
Цахилгаан холбоо	Төлбөр төлөх бэлэн байдал(WTP) сайжрах, зардлын хэмнэлт		

Ихэвчлэн дээрх жишээг үндэслэн төслийн эдийн засгийн үр ашгийг тооцох ба төслийн зорилго, зорилтод шууд хамааралтай бусад үзүүлэлтийг мөн үр ашиг гэж тооцон оруулж болно.

Түүнчлэн үр ашгийг тооцохдоо мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг онцгойлон анхаарах хэрэгтэй.

## (2) Үр ашгийг тодорхойлох

Үр ашгийг хоёр ангилна.

① “Төслийн хүрээнд шинээр бий болох бараа, ажил, үйлчилгээ, түүний ашиглалтын үнэ цэнэ”

Энэ төрлийн эдийн засгийн үр ашгийг тооцохдоо төслийн үйл ажиллагааны дүнд шинээр бий болсон шууд үр нөлөөг хамруулах ба “Үр дүнд суурилсан арга барил”-д үндэслэдэг. Энэхүү арга барил нь төслийн хүрээнд шинээр бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэн болон тэдгээрийг ашигласнаар бий болох үнэ цэнд анхаарал хандуулж, үр ашгийг тооцдог. Аль үе шатанд төслийн эдийн засгийн үр ашгийг тооцох нь тухайн төслийн зорилго, зорилтоос хамаарах тул төсөл тус бүрээр тогтоох шаардлагатай.

② “Төслийн хүрээнд хэмнэгдсэн зардал”

Энэ төрлийн эдийн засгийн үр ашгийг тооцохдоо төслийн үйл ажиллагааны дүнд хэмнэгдэж буй орлуулах зардлын хэмнэлтийг үр ашиг гэж тооцно. Жишээлбэл, өмнө нь ус түгээлтийн машинаас харьцангуй өндөр үнэтэй ус авч хэрэглэдэг байсан хүмүүс хямд өртөг бүхий цэвэр усны шугамд холбогдсоноор бий болох зардлын зөрүүг орлуулах зардлын хэмнэлт гэдэг ба үүнийг эдийн засгийн үр ашиг хэмээн тооцдог. Мөн айл өрх цахилгааны

шугамд холбогдсоноор түлшний зардал хэмнэгдэж, энэ нь орлуулах зардлын хэмнэлт болж тооцогдоно.

### (3) Үр ашгийг тооцох

Тодорхойлсон үр ашгаа тус бүрд нь (нэгж үнэ \* тоо хэмжээ /төсөөллийг багтаасан/) гэсэн томъёогоор мөнгөн дүнд шилжүүлж, нийт үр ашгийг тооцоолон гаргана. Нэгжийн үнэ болон тоо хэмжээг тодорхойлохдоо дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

Нэгжийн үнэ:

① Зах зээлийн үнэ тодорхой бус зүйлсийн хувьд тус бүрд нь үнэ өртгийг тооцно. Жишээлбэл, авто зам барьснаар бий болж буй зорчих хугацааны зардлын хэмнэлтийн нэгж үнийг тооцох бол голлох тээврийн хэрэгслийн төрөл (суудлын, их, бага даацын ачааны, автобус) тус бүрээр хэмнэгдсэн цаг хугацааны үнэ цэнийг тооцно гэсэн үг юм.

② Статистик тоо мэдээллийг авах боломжгүй бол дундаж цалин, өрхийн орлого зэргээс нэгж хугацааны үнэ цэнийг тооцоолон, тодорхой тооны жолоочоос асуулга, судалгаа авах зэргээр тус бүрийн зарцуулагдах хугацааны хэмнэлтийн үнэ цэнийг тооцно.

③ Өөр орлуулах байгууламж, үйлчилгээ байхгүй тохиолдолд эсхүл тухайн үйлчилгээний хэрэглэгч болон ашиг шимийг хүртэгч нь өөр өөр байх хотын дэд бүтцийн төслийн тухайд бодит эрэлт хэрэгцээг тодорхойлох нь хүндрэлтэй тул төлбөр төлөх бэлэн байдал (WTP) зэргийг нэгж үнийг тооцоход ашигладаг.

Тоо хэмжээ:

Тоо хэмжээний төсөөллийг гаргахдаа дундаж хэрэглээнд үндэслэн тооцоо хийхээс гадна урьдчилан дэвшүүлж буй таамаглал оновчтой эсэх, ашиглагдаж буй тоон мэдээллийн чанар, хэтэрхий өөдрөгөөр төсөөлж буй эсэх зэрэгт анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, эрэлтийн суурь хүчин зүйл болох хэрэглэгч хүн амын тоо, эдийн засгийн нөхцөл байдал зэргийг тодорхойлсны үндсэн дээр тэдгээрийн төсөөллийг хийж (прогноз утга), түүнд гарч буй өөрчлөлт нь төслийн хүрээнд дэвшүүлсэн прогнозтой таарч байх шаардлагатай байдаг.

“9-2. Үр ашгийн тооцоолол”-ыг бөглөхөд дээрх зүйлсийг анхаарах хэрэгтэй ба санхүүгийн шинжилгээний Хүснэгт 8-4 дэх Орлогын тооцооллын хүснэгтийн бөглөх аргачлалтай ижил тул энд тусгайлан дэд хүснэгт нэмээгүй бөгөөд нэгж үнэ, тоо хэмжээг нь гаргах боломжгүй үр ашгийн тухайд жил бүр тухайн үр ашгийн дүнг тооцон гаргаж бөглөх шаардлагатай.

### 3) Цэвэр үр ашиг ба ЗҮАТ-ны үр дүнг тооцох

Цэвэр үр ашиг болон ЗҮАТ-ны үр дүнг тооцохдоо, “Хавсралт 9-1”, “Хавсралт 9-2”-т үндэслэн “Хавсралт 9. Эдийн засгийн шинжилгээ”-ний хүснэгтийг гүйцээн боловсруулж, ЭЗӨДХ, эдийн засгийн үр ашгийн утгад хөрвүүлсэн ЦӨҮЦ, Үр ашиг, зардлын харьцааг тооцон гаргана. Хүснэгт бөглөх аргын хувьд Хүснэгт 8 дахь Санхүүгийн шинжилгээний хүснэгттэй ижил бөгөөд ЦӨҮЦ-ийг тооцоход ашиглагдах хорогдуулалтын хувь нь салбар бүрээр тодорхойлогдох нийгмийн хорогдуулалтын хувь байхыг анхаарна уу.

## 1.4 Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас

Төслийн саналын маягтыг бөглөж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, “Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас”-ны дагуу бүрдлийг шалгаж, Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Зураг 23. Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас

Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас					
ТЭЗ:					
Төслийн нэр:					
№	Бичиг баримт	Бүрдэл	Шалгасан /ТЭЗ/	Тайлбар	Хянасан /УХОХ-ийг боловруулах, тодотгох чиг үүрэг бүхий бүтцийн нэгж/
1	Урьдчилсан үнэлгээний хуудас	1 Төслийн лавлагаа мэдээлэл			Хянасан
		2 Урьдчилсан үнэлгээ	Бэлтгэсэн		ДУУУ нэхэн бүрдүүлэх
		3 Дүгнэлт			
2	Төслийн саналын маягт	1 Хүснэгт. 1 Төслийн үндсэн мэдээлэл	Бэлтгэсэн		
		2 Хүснэгт. 2 Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин			
		3 Хүснэгт. 3 Санхүүжилт болон төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө			
		4 Хүснэгт. 4 Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт			
		5 Хүснэгт. 5 Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байдлаар			
		6 Хүснэгт. 6 Төслийн дэд бүтцийн хэрэгцээ			
		7 Хүснэгт. 7 Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ			
		8 Хүснэгт. 8 Санхүүгийн шинжилгээ			
		8-1 Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Санхүүгийн шинжилгээ)			
		8-2 Зардлын задаргаа (Санхүүгийн шинжилгээ)			
8-3 Зардлын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ)					
8-4 Орлогын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ)					
9 Хүснэгт. 9 Эдийн засгийн шинжилгээ					
9-1 Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Эдийн засгийн шинжилгээ)					
9-2 Үр ашгийн тооцоолол (Эдийн засгийн шинжилгээ)					
10 Хүснэгт. 10 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт			Бэлтгэвгүй		
3	Хавсралт	1 Суурь судалгаа			
		2 Бодлогын судалгаа			
		3 ТЭЗУС		Шаардлагатай	
		4 ТЭЗҮ			
		5 Зураг төсөл			
		6 БОНБУ (ерөнхий)			
		7 БОНБУ (нарийвчилсан)			
		8 Газрын гэрчилгээ			
		9 Холбогдох тусгай зөвшөөрлүүд	/	/	
		10 Ийнхөрийн судалгаа			
		11 Төслийн хүрээнд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрийн хуулбар	/	/	
		12 Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө			
		13 Эрсдлийн шинжилгээ			
		14 Мөнгөн урсгал / Санхүүгийн тайлан			Хавсаргасан
		15 Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн өгөгжлийн дотоод хувь)			
		16 Эдийн засгийн шинжилгээ (Эдийн засгийн өгөгжлийн дотоод хувь)			Үгүй
4	ТЭЗ-ийн жж бүрэн үнэлгээний хуудас				
5	Төслийн жж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт		Ирүүлсэн		
УХОХ-ийг боловруулах, тодотгох чиг үүрэг бүхий бүтцийн нэгжийн дүгнэлт					

## 2. ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

### 2.1 Төслийн хэрэгжилтийн тайлан

УХОХ-ийн төслийн жагсаалтад багтсан төслийн хэрэгжилтийн явцыг Засгийн газрын холбогдох журамд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйд үндэслэн хийж гүйцэтгэнэ УХОХ-ийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгтийг төслийн саналын маягтад тусгасан.

### 2.2 Хэрэгжилтийн тайлангийн хүснэгт

УХОХ-ийн төслийн хэрэгжилтийг ажлын явц ба санхүүжилтийн гүйцэтгэл тус бүрээр тайлагнана.

УХОХ-ийн төслийн хэрэгжилтийн тайлан нь төслийн үйл ажиллагаа болон санхүүжилт төлөвлөгөөний дагуу хэрэгжиж буй эсэхэд явцын үнэлгээ өгөхөөс гадна хүлээгдэж байсан үр дүн, зорилгодоо хүрч байгаа эсэхэд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ хийх зорилготой. Түүнчлэн гадаад, дотоод эрсдэлт хүчин зүйлсийн өөрчлөлтийг нягтлах эрсдэлийн хяналт-шинжилгээг багтаана.

### 2.3 Төслийн саналын маягт, хэрэгжилтийн тайлангийн хүснэгтийн уялдаа

Доорх тайлангийн хүснэгтийн ногоон өнгөтэй хэсэг нь бусад хүснэгтээс холбоосоор бөглөгдөнө. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үед бөглөх хэсэг шар өнгөтэй хэсэг нь зөвхөн төслийн явцыг харуулах хэсгүүд байна. Эдгээр хэсгийг хэрхэн бөглөх эсвэл төслийн саналын маягтын аль хүснэгтээс бөглөгдөхийг “ажлын явц”, “санхүүжилтийн гүйцэтгэл” хэсэгт хуваан тайлбарлав.

Зураг 24. УХОХ-ийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт

Хавсралт. 10

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт

Төслийн нэр: \_\_\_\_\_  
Хэрэгжих хугацаа: \_\_\_\_\_

Ажлын явц							Санхүүжилтийн гүйцэтгэл								
Төслийн зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Төслийн ажлын явц					Нийт ажлын явц хувь (%)	Нийт төсөвт өртөг	Эх үүсвэр	Санхүүжилт /сая төг./					Нийт гүйцэтгэл, хувь (%)
		Суурь түвшин (20-оны эцэст)	20-оны хэрэгжилт, явц (%)	2С-оны хэрэгжилт						20-оны төсөвт өртөг	20-оны гүйцэтгэлийн дүн	20-оны санхүүжилт			
				20-онд төлөвлөсөн	20-оны биелэлт	20-оны хэрэгжилт, явц (%)						20-оны төсөвт өртөг	20-оны гүйцэтгэл	20-оны гүйцэтгэл, хувь (%)	
Төслийн зорилго							Нийт өртөг								
Зорилт 1	②	③	④	⑤	⑥	⑦	Зорилт 1-ийн санхүүжилт	⑩					⑪		
Зорилт 2							Зорилт 2-ийн санхүүжилт								
Зорилт *							Зорилт *-ийн санхүүжилт								
							<b>Нийт дүн</b>								
20-оны төслийн ажлын явцын үнэлгээ <sup>1*</sup>	⑧ %	Ажлын явц, тайлбар	⑨				20-оны санхүүжилтийн гүйцэтгэлийн үнэлгээ <sup>1*</sup>	⑫ %	Санхүүжилтийн гүйцэтгэл, тайлбар	⑬					
		Төслийн зорилго, зорилтыг биелүүлэхэд учирч буй саад бэрхшээл, эрсдэл	⑩						Төслийн санхүүжилттэй холбоотой учирч буй саад бэрхшээл, эрсдэл	⑭					
ТӨЗ-ийн нэгдсэн дүнгээт <sup>2*</sup>		<input type="checkbox"/> Хэрэгжих, дуусаж <input checked="" type="checkbox"/> Үргэлжлүүлж <input type="checkbox"/> Эргэлтэй, дахин үнэлж			Нэмэлт тайлбар:		⑮								

\*Жич:

1. Энэ хэсгийн үнэлгээг төслийн ерөнхийлөн захиралчийн хяналт-шижилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагч Засгийн газрын холбогдох журамд заасан хяналт-шижилгээ, үнэлгээний арга зүйд үндэслэн хийж гүйцэтгэнэ.

2. Төслийн ерөнхийлөн захиралч нь төслийн ажлын явц, санхүүжилтийн гүйцэтгэлийн хувиас гадна тухайн төслийг хэрэгжүүлэхэд учирч буй саад, бэрхшээл, эрсдэлт хүчин зүйлс зэргийг харгалзан нэгдсэн дүнгэмтэй гаргана. Төслийн төсөвт өртөг, хэрэгжих хугацаанд өөрчлөлт ороон тохиолдолд тухайн төслийг эргэлзээтэй буюу дахин үнэлэх ангилалд оруулж, холбогдох арга хэмжээг авна. Дахин үнэлэх аргачлал нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих буй төслийг дахин үнэлэх аргачлал"-тай уялдана.

### 2.3.1 Төслийн нэр, хэрэгжих хугацаа

#### ① Төслийн нэр, хэрэгжих хугацаа

"Хавсралт 1. Төслийн үндсэн мэдээлэл" хүснэгтийн харгалзах хэсгээс тус тус бөглөгдөнө.

### 2.3.2 Ажлын явц

#### ② Төслийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт

Төслийн үйл ажиллагааг зорилт тус бүрээр хувааж бичнэ. Зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт нь Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө Хавсралт 4. Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт хүснэгтээс бөглөгдөнө.

#### ③ Суурь түвшин

Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө хүснэгтийн "Он оноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г үндэслэн бөглөнө.

#### ④ 20..оны хэрэгжилт, явц

Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө-ний "Өнгөрсөн хугацааны төслийн явц"-аас бөглөгдөнө.

#### ⑤ 20..онд төлөвлөсөн

Хавсралт 4. Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт хүснэгтээс бөглөгдөнө.

#### ⑥ 20.. оны биелэлт, 20.. оны хэрэгжилт, явц (%)

"20.. оны биелэлт"-эд тухайн оны төлөвлөсөн зорилго, зорилт биелсэн эсэхийг үгээр, "20.. оны хэрэгжилт, явц (%)" баганад хувиар илэрхийлнэ.

#### ⑦ Нийт ажлын явц, хувь (%)

Зорилт тус бүрийн ба нийт ажлын явцыг хувиар илэрхийлнэ.

#### ⑧ 20..оны төслийн ажлын явцын үнэлгээ

"20..оны төслийн ажлын явцын үнэлгээ"-г ТЕЗ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагч Засгийн газрын холбогдох журамд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйд үндэслэн хийж гүйцэтгэнэ.

#### ⑨ Ажлын явц, тайлбар

Хавсралт 1. Төслийн үндсэн мэдээлэл хүснэгтийн "6. Төслийн танилцуулга" хэсгээс төслийн ерөнхий мэдээллийг бичиж, ажлын явцыг товч, тодорхой тайлбарлана. Ажлын явцыг бичихдээ төслийн хувьд тухайн жилд төлөвлөснөөс өөрчлөгдсөн зүйл (гэрээний хугацаа сунгасан гэх мэт) байвал заавал тусгах ба төлөвлөгөө, биелэлтийн хооронд гарсан зөрүүтэй байдлын шалтгаан, авсан арга хэмжээний талаар тайлбарлана.

#### ⑩ Төслийн зорилго, зорилтыг биелүүлэхэд учирч буй саад бэрхшээл, эрсдэл

Төслийн үйл ажиллагаа хүлээгдэж буй үр дүнд хүрч чадаагүй бол учирч буй саад бэрхшээлийг, эрсдэлт хүчин зүйлсийн хамт тайлбарлана. "Эрхэм зорилго, төслийн зорилго, зорилт" гэж төслийн саналын маягтын "Хавсралт 4. Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт"-ийн харгалзах хэсгүүдийг хэлнэ. "Эрсдэл" гэж төслийн саналын маягтын "Хавсралт 1. Төслийн үндсэн мэдээлэл" –ийн "25. Эрсдэл" хэсгийг хэлнэ.

### 2.3.3 Санхүүжилтийн гүйцэтгэл

#### ⑪ Нийт төсөвт өртөг

"Нийт төсөвт өртөг"-ийг төслийн зорилго, зорилтуудад харгалзуулан бичнэ. Төсөвт өртөг өөрчлөгдсөн бол тухайн онд анх төлөвлөж байсан дүнг тусгана. "Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний "Нийт төсөвт өртөг" хэсгийг үндэслэх ба хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжих бол эх үүсвэр тус бүрээр тайлбарлана.

⑫ **Эх үүсвэр**

“Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний “Төлөвлөж буй эх үүсвэр” хэсгийг үндэслэн бичнэ.

⑬ **Суурь он, тухайн оны төсөв ба гүйцэтгэл**

“Суурь онд хийгдсэн санхүүжилт дүн” болон “20.. оны төсөв” нь “Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө” хүснэгтээс бөглөгдөх ба “20.. оны гүйцэтгэлийн дүн”-г мөн дээрх хүснэгтийг үндэслэн бичнэ. “20..оны гүйцэтгэл” хэсэгт тухайн онд санхүүжилт хийгдсэн дүнг тоогоор, “20.. оны гүйцэтгэл, хувь” хэсэгт тухайн оны төсөв ба гүйцэтгэлийн харьцааг хувиар тэмдэглэнэ.

⑭ **Нийт гүйцэтгэл, хувь**

Төслийн нийт санхүүжилтийн гүйцэтгэлийн хувийг тэмдэглэнэ.

⑮ **20.. оны санхүүжилтийн гүйцэтгэлийн үнэлгээ**

ТЕЗ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагч Засгийн газрын холбогдох журамд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйд үндэслэн хийж гүйцэтгэнэ.

⑯ **Санхүүжилтийн гүйцэтгэл, тайлбар**

Төслийн агуулгыг санхүүжилтийн талаас тайлбарлаж “Хавсралт 1.Төслийн үндсэн мэдээлэл”, “Хавсралт 3. Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө” хүснэгтүүдийг үндэслэн товч, тодорхой бичих ба гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төслийн хувьд санхүүжилт хийгдсэн гадаад валютын нэр, хөрвүүлсэн огноо, ханш, дүнг тодорхой дурдана. Санхүүжилтийн талаар гарсан өөрчлөлт, ялангуяа санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй байсан төслийн тухайд тухайн онд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг тодорхой дурдана.

⑰ **Төслийн санхүүжилттэй холбоотой учирч буй саад бэрхшээл, эрсдэл**

Санхүүжилтийн гүйцэтгэл дутуу эсвэл илүү байсан шалтгааныг дурдаж, гадаад болон дотоод эрсдэлт хүчин зүйлс өөрчлөгдөн төслийн хэрэгжилтэд нөлөөлөхөөр бол энэ талаар тайлбар хийнэ. Үүнээс шалтгаалж хөрөнгө оруулах шийдвэр гаргасан эдийн засгийн үндэслэлд нөлөөлөх эсэх, шинээр хүрээлэн буй орчны асуудал үүсэх эсэх талаар нарийвчлан тайлбарлана.

⑱ **ТЕЗ-ийн нэгдсэн дүгнэлт**

ТЕЗ нь төслийн ажлын явц, санхүүжилтийн гүйцэтгэлийн хувиас гадна тухайн төслийг хэрэгжүүлэхэд учирч буй саад, бэрхшээл, эрсдэлт хүчин зүйлс зэргийг харгалзан нэгдсэн дүгнэлтийг гаргана. Төслийн төсөвт өртөг, хэрэгжих хугацаанд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн төслийг эргэлзээтэй буюу дахин үнэлэх ангилалд оруулж, холбогдох арга хэмжээг авна. Дахин үнэлэх ангилалд оруулсан шалтгааныг “Нэмэлт тайлбар” хэсэгт товч дурдана. Дахин үнэлэх аргачлал нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал”-тай уялдана.

---oOo---